



Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ТӨСВИЙН
ХӨРӨНГИЙН ҮР АШГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

2020 оны 10 дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН**

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	
Хүснэгтийн товъёг	
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	

БҮЛЭГ 1. ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО ОНОВЧТОЙ БАЙГАА ЭСЭХ

А.1 Боловсролын тухай болон холбогдох бусад хуульд заасан зарим журмыг батлаагүй, батлагдсан дүрэм, журмуудын зарим нь бодит хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.....6

А.1.1 Зарим эрх зүйн актыг бодит байдалд нийцүүлж өөрчлөөгүйгээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.....6

А.2 Сургалтын материаллаг орчныг бүрдүүлэх арга хэмжээ авсан хэдий ч хүртээмжтэй бус, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ дутагдалтай байна.....8

А.2.1 Сургалтын орчин багш, сурагчдад хүртээмжтэй бус байна.....8

А.2.2 Ерөнхий боловсролын гурван сургуульд хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа тасалдах, багш ажилтан, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байна.....9

А.2.3 Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ дутмагаас суралцагч эзэмшвэл зохих мэдлэг, үр чадварыг бүрэн эзэмших боломжгүй болох үр дагавартай байна.....15

А.3 Төсвийн төлөвлөлтийг боловсруулах, төсөв батлах, хуваарилах, зарцуулах, хяналт тавих үйл явц хуулийн хүрээнд хангалттай хэрэгжээгүй, төсвийн сахилга бат алдагдаж байна.....18

А.3.1 Төсвийн төлөвлөлт, хуваарилалтын оновчгүй байдлаас шалтгаалж төсөвт олон удаа өөрчлөлт оруулсан, төсвийн зарчим, үр ашигт байдлыг хангаж ажиллаагүй байна.....18

А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг хянаагүй, төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй байна.....24

БҮЛЭГ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ ХАНГАГДАЖ БАЙГАА ЭСЭХ

Б.1 Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн дутагдалтайгаас сургалтын хөтөлбөрийн үр дүн хангалтгүй, сурлагын чанарын, үнэлгээ бодитой бус байна.....28

Б.1.1 Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн дутагдалтайгаас хөтөлбөрийн үр нөлөө хангалтгүй байна.....28

Б.1.2 Суралцагчдад мэдлэг, чадварыг хугацаанд нь бүрэн олгож чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, ахиц, амжилтыг тухай бүр үнэлж дүгнэх боломжгүйгээс сургалтын чанарын үнэлгээ бодитой бус байна.....31

Б.2 Боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналт үр нөлөөгүй, үр дүн хангалтгүй байна.....33

Б.2.1 Боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтын арга зүйгээ өөрчилж, хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх шаардлагатай байна.....33

Б.2.2 Сургуулиудын үйл ажиллагаанд тавьсан хяналтаар илэрсэн зөрчил давтагдан гарч байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.....37

Холбогдох байгууллагын санал:.....40

ДҮГНЭЛТ:41

ЗӨВЛӨМЖ:41

ХАВСРАЛТУУД:.....43

Товчилсон үгийн тайлбар

БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
БСШУСЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЧҮС	Чанарын үнэлгээний судалгаа
БНБД	Барилгын норм ба дүрэм
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗТБХБ	Зам тээвэр барилга хот байгуулалт
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БДБТХ	Бага дунд боловсролын тухай хууль
ТАХ	Төсөл арга хэмжээ
БТХ	Боловсролын тухай хууль
АУБ	Анги удирдсан багш
ЕБ	Ерөнхий боловсрол
МУ	Монгол Улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
БГАҮТ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр
БҮБЗ	Бараа үйлчилгээний бусад зардал
ҮЦХ	Үдийн цай хөтөлбөр
УИХ	Улсын Их Хурал
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БН	Бэлтгэн нийлүүлэгч
ОУБ	Олон улсын байгууллага
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Гадаад болон дотоод орчны аюулгүй байдал	13
Хүснэгт 2	Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж	14
Хүснэгт 3	Мэргэжлийн бус багш номын санч	15
Хүснэгт 4	Мэргэжил дээшлүүлсэн багш	16
Хүснэгт 5	Ойрын 5 жилд дутагдах багшийн судалгаа	17
Хүснэгт 6	Төсвийн төсөл	18
Хүснэгт 7	Сангийн яамны хянасан төсөв	19
Хүснэгт 8	2017 оны ЕБС-ын төсөв	20
Хүснэгт 9	2018 оны ЕБС-ын төсөв	20
Хүснэгт 10	2019 оны ЕБС-ын төсөв	20
Хүснэгт 11	Зардлын дүнд оруулсан өөрчлөлт	21
Хүснэгт 12	Дотуур байрны хувьсах зардал	22
Хүснэгт 13	Сурах бичгийн судалгаа	23
Хүснэгт 14	Үдийн цай хөтөлбөрийн хүүхэд өдөр	25
Хүснэгт 15	Сургуулийн хэв шинж болон сурлагын амжилтын хамаарал	28
Хүснэгт 16	Улсын шалгалтын дүн 2018-2019 он	29
Хүснэгт 17	ЭЕШ-ийн нэгтгэл	30
Хүснэгт 18	ЧҮТ-өөс зохион байгуулсан шалгалтын гүйцэтгэлийн мэдээ	32

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Замын-Үүд сумын лаборатори I сургууль	10
Зураг 2	Хатанбулаг сумын ЕБС-ын дотуур байр	11
Зураг 3	Замын-Үүд сумын ЕБ-ын III сургууль	11
Зураг 4	Сайншанд сумын ЕБ-ын I сургуулийн химийн урвалж бодис	13
Зураг 5	Сайншанд сумын ЕБ-ын V сургуульд нийлүүлэгдсэн ширээ сандал	14

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	-	-

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ЕБС-ийн сургалтын орчны судалгаа	-
Хавсралт 2	ЕБС-ийн орон нутгийн хэрэгцээ шаардлага, хамран сургалтын судалгаа	-
Хавсралт 3	Багш боловсон хүчний судалгаа	-
Хавсралт 4	ТӨ сургуулиудын СТ-ийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн судалгаа	-

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийнэ.
Аудитын зорилт	“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх; ➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг БСУГ, ЗДТГ, МХГ, төрийн өмчийн 12, хувийн хэвшлийн 1 сургуулийн 2017-2019 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон зээл олголт, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 6 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Лүндэгмаа, гэрээт аудитор З.Давааням, Б.Ариунбаатар хамтран гүйцэтгэв. Аудитын төлөвлөгөөг 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн батлуулж, талбарын ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүртэл гүйцэтгэж, цуглуулсан баримт материал, нотлох баримт, судалгааг нэгтгэх, дүн шинжилгээ хийж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, 2020 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн дотор ҮАГ, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, БСУГ-т хүргүүллээ.

БҮЛЭГ 1. Ерөнхий боловсролын эрх зүйн зохицуулалтыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж, багш, мэргэжлийн ажиллагсдыг сум орон нутагт тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

А.1 Мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх;

Боловсролын тухай болон холбогдох бусад хуульд заасан зарим журмыг батлаагүй, батлагдсан дүрэм, журмуудын зарим нь бодит хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.

А.1.1 Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, норм норматив хэрэгцээ шаардлагыг хангасан, харилцан уялдаатай байгаа эсэх

Зарим эрх зүйн актыг бодит байдалд нийцүүлж өөрчлөөгүйгээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

- Хуульд заасан дүрэм, журам, норм нормативыг баталсан уу?

Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай, хуульд 40 дүрэм, журмыг батлахаар тусгасан ч дараах журмуудыг батлаагүй байна. Тухайлбал:

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7.5 -д Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар тусгасан ч журам батлагдаагүй, 2019 онд 2 удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, ЕБС-ын багш нараас санал байна. Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг батлаагүйгээс багшийн хөгжлийн түвшнийг тодорхойлох боломжгүй байна.

Боловсролын тухай хуулийн 28.1.25-д ерөнхий боловсролын лаборатори сургуулийн тусгай арга хэмжээ, хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтыг хэрэгжүүлэх журмыг батлаагүйгээс лаборатори сургууль тусгай арга хэмжээгээр багш нарын туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа багассан, ердийн сургалттай боловсролын байгууллагаас ялгарах онцлог, давуу байдлаа алдахад хүргэсэн байна.

Хуульд заасан дүрэм журам, зааврын заримыг боловсруулж батлаагүй байна.

- Салбарын яам захиргааны хэм хэмжээний актад холбогдох талуудын саналыг тусгасан уу?

Холбогдох хуулийн дагуу дүрэм, журам боловсруулах, санал асуулга явуулах, хэлэлцүүлэг зохион явуулах зэрэг зохион байгуулалт нь яамны чиг үүрэг учраас тус асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл аймгийн түвшинд байхгүй байна.

- Мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж шинэчилсэн үү?

Боловсролын тухай хуульд 2018 онд ЕБС-ийн захирлыг сумын Засаг дарга томилох, чөлөөлөхөөр нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд хуулийг дагаж мөрдөх хугацааг УИХ-аар авч хэлэлцсэний дагуу 2 удаа хойшлуулан 2020.07.01-ний өдрөөс хэрэгжихээр болсон байна.

Аймаг, нийслэлийн боловсролын газрын үлгэрчилсэн журмын 2.7.1¹-д зааснаар аймгийн БСУГ нь ЕБС-ийн захирлын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг ТАЗ-өөс баталсан журмаар зохион байгуулах, энэхүү сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн аймаг, сумын Засаг дарга томилох, БСУГ-ын саналыг үндэслэн чөлөөлөхөөр хуульчилсан байна.

Аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлөөс төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт зохион байгуулж, тогтоол хүргүүлсний дагуу аймгийн Засаг дарга ЕБС-ийг захирлыг томилсон нь хууль, журамд заасантай уялдаагүй байна. Тодруулбал: Аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлийн 2017 оны 05 тогтоолыг үндэслэн Аймгийн Засаг даргын захирамжаар 2016-2019 онуудад нийт 21 захирлыг томилжээ. Аймгийн БСУГ-аас 2018 онд Эрдэнэ сумын ЕБС-ийн захирлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үнэлгээг гарган аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Аймгийн Засаг даргын 2020.06.26-ны А/493 тоот захирамжаар ЕБС-ийн захирлуудыг ажлаас чөлөөлсөн боловч сумдын Засаг дарга нар томилох захирамж гаргахдаа хууль, журмын дагуу сонгон шалгаруулалт явуулаагүй байна. Эдгээр нөхцөл байдал нь салбарын мэргэжлийн байгууллагын оролцоог багасгасан, хуульд заасан үүргээ хэрэгжүүлж чадахгүйд хүргэсэн байна.

Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоол, 2019 оны 24 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон. МУ-ын Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан хувьсах зардлын дундаж нормативын хэмжээгээр тооцож буй цалингийн сан нь албан тушаалын цалингийн сүлжээгээр бодсон хэмжээнээс бага байна. Иймд хувьсах зардлын дундаж нормативыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж шинэчлэх шаардлагатай байна.

Бага дунд боловсролын тухай хуулийн 12.10-д заасны дагуу ЕБС-ийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив нь аймгийн сургуулиудад хэрэгжүүлэхэд хэт олон, мөн яамнаас хангалттай төсвийг баталдаггүй зэрэг шалтгаанаар хэрэгжүүлэх боломжгүй байна. Дээрх шалтгааны улмаас дотоод хяналтын ажилтны орон тоог ЕБС-иуд батлаагүй хавсран гүйцэтгүүлэхээр тусгасан байна.

БСШУС-ын 2013 оны А/293 тоот тушаалаар баталсан багш, ажилтны ажлыг үнэлэх, дүгнэх журамд 5 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгөхөөр заасан байна. Шалгуур үзүүлэлтүүд нь хэт их хялбарчилсан, үр дүнд суурилсан үнэлгээний шалгуур хангалтгүй, багш нарын бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартыг хангах, биелүүлэх талын үнэлгээ дутмаг байна.

2018 оны А/425 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журмын 3.20-д "Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ" гэж заасан. Суралцагчийн сурлагын чанарын мэдээлэл нууц болсноос сурагч нэг бүрийн сурлагын түвшинтэй танилцах, сурлагын амжилт тааруу байгаа үндэслэлийг зөв тодорхойлох боломжгүй болсон байна.

¹ 2.7.1. Сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлөөс баталсан журамд заасны дагуу зохион байгуулах, үр дүнг ил тод, нээлттэй мэдээлэх;

Энэхүү нууцлалтай холбоотойгоор бага, дунд ангийн сурагчийн мэдлэг, чадварын үнэлгээг ЧҮС-р, ахлах ангийн үнэлгээг ЭЕШ-аар тус тус үнэлж байгаа нь учир дутагдалтай байна.

Чанарын үнэлгээний журмын 6.5-д “Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.” гэж заасан. БҮТ-өөс зохион байгуулж байгаа ЧҮС-ны даалгавар боловсруулалт нь сурагчийн хийж гүйцэтгэх хугацаатай уялдаагүй, хэт бага хугацаатай байсан байна.

Зарим эрх зүйн актыг бодит байдалд нийцүүлж өөрчлөөгүйгээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

А.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн боловсон хүчин, хүртээмжтэй материаллаг орчин бүрдсэн эсэх

Сургалтын материаллаг орчныг бүрдүүлэх арга хэмжээ авсан хэдий ч хүртээмжтэй бус, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ дутагдалтай байна.

А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн эсэх

Сургалтын орчин багш, сурагчдад хүртээмжтэй бус байна.

- Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-аас төрийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлж байна уу?

Боловсролын тухай хуулиар заасан ИТХ-ын бүрэн эрхэд “Боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх, орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавина гэж заажээ.

Аймгийн ИТХ-аас 2016-2019 онуудад орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлаагүй байна. Аймгийн ИТХ-ын 2017 оны 40 дүгээр тогтоолоор “Маргаашийн нар багшийн гар дээр мандана” дэд хөтөлбөрийг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

- "Нэг ангид ногдох хүүхдийн тоо зохих түвшинд байна уу? /байршил, хэв шинж, сургалтын чанараас шалтгаалан хүчин чадлыг бүрэн ашиглаагүй, цөөн хүүхэдтэй анги, сургууль, анги дүүргэлт хэтэрсэн байх/"

Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаалаар баталсан ЕБС-ийн барилгын төлөвлөлтийн дүрмийн 1.3.6-д “Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 30 хүүхдээс ихгүй байна” гэж заажээ.

Аймгийн хэмжээнд ЕБС-д нэг бүлэгт байх хүүхдийн тоо дунджаар 2017-2018 онд 29 хүүхэд, 2018-2019 онд 30 хүүхэд, 2019-2020 онд 31 хүүхэд байна. Сургуулийн байршил, хэв шинжээс хамаарч сургуулиудын хүүхдийн тоо харилцан адилгүй байгаа ба хүн амын төвлөрөл ихтэй Сайншанд, Замын-Үүд сумдын ЕБС-д нэг бүлэгт байх хүүхдийн тоо зохих түвшнээс хэтэрсэн байна. Харин сумдын суурь боловсролын сургуулиудад хүүхдийн тоо зохих түвшнээс доогуур байна. Тухайлбал:

- Сайншанд сумын I, II сургууль, Иххэт, Замын-Үүд сумын ЕБС-д 2017-2018 онд нэг бүлэгт дунджаар 36 хүүхэд, 2018-2019 онд 36 хүүхэд, 2019-2020 онд 38 хүүхэд байна.
- Алтанширээ, Улаанбадрах, Сайхандулаан, Эрдэнэ сумын ЕБС-д нэг бүлэгт байх хүүхдийн тоо дунджаар 2017-2019 онд 17 хүүхэд, 2019-2020 онд 18 хүүхэд байна.

Ерөнхий боловсролын сургуулийн нэг ангид суралцах хүүхдийн тоо харилцан адилгүй байна.

- Шинээр баригдсан сургуулийн барилгын хүчин чадлыг оновчтой тодорхойлсон уу? /2016-2018 онд /

Дорноговь аймгийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017 онд Замын-Үүд суманд 960 хүүхдийн хүчин чадалтай бүрэн дунд боловсролын сургууль, 2019 онд Сайншанд суманд III сургуулийг өргөтгөн 320 хүүхдийн хүчин чадалтай бага сургууль шинээр ашиглалтад орсон байна.

Сургууль ашиглалтад орохоос өмнөх жилүүдэд Замын-Үүд сумын 1000 хүүхдийн хүчин чадалтай ЕБ-ын I сургуульд 1807 суралцагч, 928 хүүхдийн хүчин чадалтай ЕБ-ын II сургуульд 1408 сурагч суралцаж, хүчин чадлаасаа 1287 хүүхдээр давж 3 ээлжээр хичээллэж байсан байна. Шинэ III сургууль үйл ажиллагаа явуулж эхэлснээр 2 сургуулийн хүүхдийн ачаалал буурч 2 ээлжээр хичээллэдэг болсон ч 2019-2020 оны хичээлийн жилд Замын-Үүд сумын I сургуульд 1446 суралцагч, II сургуульд 1210 суралцагч, III сургуульд 1259 суралцагч байгаа нь сургуулиудын нийт хүчин чадлаас 1027 суудлаар илүү байна.

Сайншанд сумын III сургуулийн 320 хүүхдийн хүчин чадалтай бага сургуульд 2019-2020 оны хичээлийн жилд 446 хүүхэд суралцсан нь тухайн сургуулийн хүчин чадлаас 126 суудлаар илүү байна.

Шинээр барих сургуулийн урт хугацааны төлөвлөлт хийгдээгүй, цаашид хүчин чадлыг оновчтой тодорхойлох хэрэгтэй байна.

А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин, нөхцөл бүрдсэн эсэх

Ерөнхий боловсролын гурван сургуульд хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа тасалдах, багш ажилтан, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн байна.

- "Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан, зориулалтын барилга байгууламжтай байна уу? /Эдийн засгийн үр ашиггүй барилгад /сургуулийн барилга, номын сан, спорт заал, дотуур байр,/ жил бүр урсгал завсар хийх, сургуулийн эзэмшил газарт барилга байгууламж баригдаж сургалтын орчинд сөргөөр нөлөөлсөн байх, стандартын хэрэгжилт өмчийн хэлбэрээс хамааран харилцан адилгүй байх/"

ТӨ-ийн ЕБС-ын зарим барилга байгууламжийн ашиглалтын хугацаа, төлөв байдал нь Боловсролын тухай хуулийн 42.1², Барилгын норм, дүрэм³, стандарт⁴-ийг

²Боловсролын тухай хуулийн 42.1-д "Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна"

зөрчиж байна. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-03-т тоосгон барилга 40 жил, модон барилга 30, төмөр бетон 50, канад модон барилгын ашиглалтын хугацааг 30 жил байхаар заасан.

Сургуулийн барилгын ашиглагдах хугацаа дууссан /40 жилээс дээш жил ашиглагдаж байгаа/ тоосгон барилга бүхий 8 сургууль байна.

- Айраг сумын сургууль 1976 он
- Алтанширээ сумын сургууль 1974 он
- Даланжаргалан сумын сургууль 1976 он
- Дэлгэрэх сумын сургууль 1978 он
- Мандах сумын сургууль 1974 он
- Хатанбулаг сумын сургууль 1974
- Хөвсгөл сумын сургууль 1974 он
- Өргөн сумын сургууль 1974 он
- Замын-Үүд сумын лаборатори 1-р сургууль 1956 он

Эдгээр сургуулиас Хөвсгөл, Замын-Үүд сумын лаборатори сургуулиас бусад сургуульд их засвар хийгдсэн байна.

Замын-Үүд лаборатори 1 дүгээр сургууль нь 1956 онд ашиглалтад орсон, 64 жилийн насжилттай. Барилгын чанар байдал, ашиглалтын талаар аймгийн мэргэжлийн хяналтын газраас 2012, 2014, 2018 онд сургуулийн “А” корпусын барилгыг акталж шинээр барих шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан байна. Тухайлбал: Барилгын А корпусын 1 давхрын хичээлийн танхимд 2014 онд дүүжин таазыг цөмлөн 30-40 кг жинтэй шавар нурсан, сургуулийн орчинд эрсдэлд өртөх аюултай нөхцөл байдал үүссэн байна.

Зураг №1



Замын-Үүд сумын лаборатори I сургууль

МХГ-аас Барилга ашиглалтын явцад сэргээн засварлалт, засвар үйлчилгээ хийгээгүйгээс шалтгаалсан зөрчлүүдийг арилгах талаар өгсөн зөвлөмж, дүгнэлтийн дагуу холбогдох байгууллагад хандсан хэдий ч хөрөнгийн асуудлаас шалтгаалж өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй, шаардлага хангаагүй орчинд хичээл сургалтын үйл ажиллагаа явагдсаар байна. Хүүхдийн сургалтын орчны аюулгүй байдлыг хангуулах асуудлыг шийдвэрлүүлэх тухай аймгийн Засаг даргад албан шаардлага бичив.

Хатанбулаг ЕБС-ийн 60 хүүхдийн дотуур байрны дээврээс ус гоожиж доод давхрын хоолны танхимын таазыг чийгтүүлж мөөгөнцөр үүсгэх, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болсон байна. Дотуур байрны хоолны зааланд

³Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13-04-03"-ын 2 дугаар хүснэгтэд зааснаар барилга ашиглалтын нормт хугацаа дууссан, даацын үндсэн хийцийн төлөв байдал нь "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм" БНБД 22.01.01/2006-ийн шаардлагыг,

⁴Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал Ерөнхий шаардлага MNS 67852:2019 стандарт

ус нэвтрүүлэхгүй байлгахын тулд дээд давхрын өрөөнд олон сав суулга тавьж ус тосон хамгаалж байна. Дотуур байрны дээврийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх тухай аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Зураг №2



Хатанбулаг сумын ЕБС-ийн дотуур байр

Замын-Үүд сумын III сургууль ашиглалтад орсон эхний жилээс хичээлийн байрны нэгдүгээр давхрын хананд цууралт үүсэж, шал нь доошоо суулт өгсөн байна. Мөн спорт заалны шал чанарын шаардлага хангахгүй эвдэрсэн, сендвичэн дээвэр хүчтэй салхинд хөвхөлзөж, шороо тоос их орж ирдэг тул урлаг заал, спорт зааланд өвлийн улиралд сургалт, үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу биеийн тамирын хичээл орох боломжгүй байна. Сургууль болон аймгийн ГХБХБГ-аас чанаргүй ажлуудыг баталгаат хугацаанд хийлгэх хүсэлтийг гүйцэтгэгч АТТА ЧР ХХК-д удаа дараалан хандсан ч нүд хуурсан байдлаар засвар хийж иржээ.

Зураг №3



Замын-Үүд ЕБ-ын III дугаар сургууль

Барилгын асуудалд холбогдох газраар дүгнэлт гаргуулж шийдвэрлүүлэх тухай аймгийн Засаг даргад албан шаардлага бичлээ.

“Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм”-ийн 3.3⁵-т заасны дагуу барилгын 15 жил тутам сургуулийн барилга, дотуур байрны барилгад төлөв байдлын дүгнэлт гаргуулаагүй байна.

Шинэ барилгыг ашиглалтад хүлээн авахдаа барилгын чанар, ажлын гүйцэтгэлийг хангуулаагүйгээс ашиглагч байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэсэн, барилга байгууламжийн эрүүл ахуй, аюулгүй байдал алдагдсан нь хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа тасалдах, багш ажилтан, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж байна. Холбогдох эрх бүхий байгууллагаас зөрчил дутагдлыг арилгах талаар тодорхой арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

⁵ 3.3. Ашиглагч Барилгын тухай хуульд заасны дагуу 15 жил тутамд барилга байгууламжийн төлөв байдалд дүгнэлт гаргуулахаас гадна тухайн барилга байгууламжийн үндсэн хийц, бүтээцийн төрлөөс хамаарч ашиглалтын явцад техникийн үзлэг шалгалт явуулж, зохих засвар, үйлчилгээ хийх ажлыг зохион байгуулна.

- Сургуулийн анги танхимыг зориулалтын дагуу ашиглаж байна уу?

ЗТБХБ сайдын 2011 оны 305 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм”-ийн 1.4.4⁶-т заасны дагуу бага ангийн хүүхдүүдийг сургуулийн байрны 1 дүгээр давхрын анги, танхимд хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2019 оны байдлаар 15 сургуулийн 94 кабинет үйл ажиллагаа явуулах гэрчилгээ авсан байна. Төрийн болон төрийн бус өмчийн 13 сургуулийн анги кабинеттай танилцахад суралцагчдын сургалтын орчин, кабинетийн багаж хэрэгслүүд, сурах бичиг, гарын авлага, кабинет ашиглалтын байдал шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Сургуулийн шинээр баригдсан болон хуучин барилгуудад химийн хичээлийн туршилт явуулах шаардлага хангасан зориулалтын өрөө байхгүй байна. Тухайлбал: Аудитад хамрагдсан Сайншанд сумын ерөнхий боловсролын I, III, V сургууль, Сайншанд сумын Зүүнбаян багийн IV сургууль, Замын-Үүд сумын ерөнхий боловсролын I, II, III сургууль, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл, Алтанширээ, Дэлгэрэх сумын сургуулиуд химийн хичээлийн зориулалтын кабинет лаборатори байхгүй, хичээлийн хэрэглэгдэхүүн, урвалж бодис дутмаг учраас туршилтын хичээлийг явуулах боломжгүй, багш нар гарын доорх материал /давс, сода, уусмалууд гэх мэт/ ашиглан хичээл орж байна.

Замын-Үүд сумын шинээр ашиглалтад орсон сургуульд хими, физик, биологийн кабинетын өрөөг барилгын зураг төсөлд тусгайлан тусгаагүй байна. Сайншанд лаборатори 2 дугаар сургуульд химийн урвалж бодис хангалттай хэдий ч урвалж бодисыг хадгалах зориулалтын шүүгээ байхгүйгээс зориулалтын бус төмөр шүүгээнд хадгалдаг, туршилтын өрөөнд зориулалтын сорох шүүгээг гадагшаа холбох хоолой байхгүйгээс ашиглаагүй байна.

Хими, физик, технологийн зориулалтын бүрэн тоноглогдсон кабинеттай сургууль байхгүй байгаа нь анги танхим болон тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамж дутагдалтай байгаатай холбоотой байна.

Сумын зарим сургуулийн сурагчид сургалтын хөтөлбөрийн дагуу хими, физик, технологийн туршилтын хичээлээс олж авах мэдлэгийг бүрэн гүйцэд олж авч чадахгүй байдалд хүрч байна.

- "ЕБС-ийн гадаад болон дотоод орчин хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангасан уу? /ойр орчимд хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа эсэх/

2016-2018 онд ЕБС-ийн 21 сургууль, 16 дотуур байр бүгд камер, гэрэлтүүлэгтэй болсон ба гадна орчны камер 73, коридорын камер 143, ангийн камер 327, гадна 99 гэрэлтүүлэг бүрэн ажиллаж байна. Аудитад хамрагдсан 13 сургууль гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг бүрэн хангаагүй байна.

⁶ 1.4.4 Бага ангийг 1-ээс дээш давхарт төлөвлөхгүй байх нь зүйтэй. Зургийн даалгаврын дагуу бага ангийг 1-ээс дээш давхарт төлөвлөх бол тэдэнд зориулан шатны гишгүүрийн өндрийг 100-120 мм-ээс ихгүй байхаар тооцно. Дулааны улиралд ангиас шууд гадагш гарах хаалгыг амрах, тоглох болон спортын талбайтай холбож төлөвлөвөл орчин үеийн шаардлагатай уялдана.

Хүснэгт №1. Гадаад болон дотоод орчны аюулгүй байдал

Хүснэгт 1. Гадаад болон дотоод орчны аюулгүй байдал			ЕБС-ийн тоо
№	Гадаад болон дотоод орчны үзүүлэлтүүд		
1	Гадаад орчны аюулгүй байдал	Сургуулийн гадна биеийн тамирын талбайн тоног төхөөрөмж хүүхдийн аюулгүй байдлыг хангаагүй	3
2		Сургуулийн ойр орчинд замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч байхгүй	1
3		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд зорчих үүдний шат байхгүй	4
4		Хог, хаягдлын цэг хана хашаагаар тусгаарлагдаагүй	3
6		Задгай цахилгааны утас байгаа эсэх, ухсан нүх, дулааны болон бохирын онгорхой цооногтой	2
7		Хашаанаас гаднах ойр орчин /архи, тамхины худалдаа, харанхуй гудамж г.м/ эрсдэлтэй	5
8		Галын аюулгүй байдлын системгүй	6
9	Дотоод орчны аюулгүй байдал	Аваарын гарцгүй	4
10		Үүд, коридорын хэсгийг халтирч болзошгүй плитагаар хийгдсэн	8
Шаардлага хангаагүй үзүүлэлттэй нийт ЕБС-ийн тоо			13

Сайншанд 1 дүгээр сургуульд 1989 оноос эхлэн сургалтад ашигласан хугацаа нь дууссан 148 нэр төрлийн химийн хортой, аюултай бодисыг агааржуулах системгүй, зориулалтын бус битүү орчинд 31 жил хадгалагдаж байна. Эдгээр химийн бодис нь хэвийн бус үнэр ялгарах, хоорондоо исэлдэж талст ургаж эхэлсэн, гал авалцах магадлал өндөр, багш, сурагчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй, сургалтад ашиглах боломжгүй болсон, бодис хадгалах зориулалтын байр, сав байхгүй байна. Химийн бодисоо устгуулах талаар сүүлийн жилүүдэд аймгийн Засаг дарга, МХГ, ОБГ, БОАЖГ-т хандсан боловч химийн бодисыг устгах газар байхгүй гэсэн хариу өгч өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

Зураг №4



Сайншанд I сургуулийн химийн урвалж бодис

Эдгээрээс шалтгаалж сургалтын үр дүн хангалтгүй, шинээр химийн бодис авах боломжгүй болсон байна. Иймд бүх сургуулиудын химийн урвалж бодисын ашиглагдах хугацаа, хор уршгийн байдалд дүгнэлт гаргуулж эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, хугацаа дууссан бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах тухай аймгийн БСУГ-т албан шаардлага бичлээ.

ЕБС-ийн гадаад болон дотоод орчин хүүхдийн аюулгүй байдлыг бүрэн хангахгүй байгаа нь хөрөнгө санхүү, удирдлагын үйл ажиллагаа, зохион байгуулалтын асуудлаас шалтгаалжээ.

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тавилга, эд хогшил хүрэлцээтэй, зохих шаардлага хангасан байна уу? /шинэ сургуулийн хувьд/

2016-2019 онд Замын-Үүд ЕБ-ын 3 дугаар сургуульд 286,4 сая төгрөгийн тавилга, 2019 онд Сайншанд ЕБ-ын 3 дугаар сургуулийн бага сургуульд шинээр 233.6 сая төгрөгийн тавилга эд хогшил нийлүүлэгдсэн байна. Сайншанд ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн зарим ангийн ширээ сандал чанарын шаардлага хангахгүй, нийлүүлэгдээд удаагүй эвдэрсэн тул тавилгыг бэлтгэн нийлүүлэгчээр солиулжээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тавилга эд хогшил хүрэлцэхүйц, тоо хэмжээ өссөн ч зохих шаардлага хангахгүй байгаа нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

- Сургуульд бэлтгэгдсэн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сурагчдын тээврийн хэрэгслийн нийлүүлэлт, ашиглалт хангалттай байна уу? /лабораторийн тоног төхөөрөмж, ухаалаг самбар гэх мэт ашиглах боломж нөхцөл бүрдээгүй байх/

Сургуулиудад 2017-2019 онд нийт 1613.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгджээ.

Хүснэгт №2. Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж

Он	Төсвийн хөрөнгөөр /сая.төг/	Төсөл хөтөлбөрөөр /сая.төг/	Өөрийн хөрөнгөөр /сая.төг/	Бусад эх үүсвэрээс /сая.төг/	Нийт дүн
2017	441.8	68.5		225.5	735.8
2018	221.0	4.1	8.2	166.5	399.8
2019	342.7	4.6		130.4	477.7
Нийт	1005.5	77.3	8.2	522.3	1613.4

БСШУЯ-наас сургуулиудад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, ширээ сандал, шүүгээ, эд зүйлсийн үнэ өндөр, чанаргүй, сургалтын хөтөлбөрт тусагдаагүй хөрөнгө нийлүүлдэг, ирсэн зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байв. Тухайлбал: Сайншанд сумын 5-р сургууль 2015 онд ашиглалтад орсноос хойш БСШУЯ-наас нийлүүлэгдсэн ширээ сандлууд эвдэрч, засаж сэлбээд ч нэмэргүй, гагнуур авах боломжгүй болсноос 2 дахь удаагаа солигдсон байна.

Зураг №5



Сайншанд сумын V сургуульд нийлүүлэгдсэн ширээ сандал

Сургуулиудад нийлүүлэгдсэн эмэгтэй технологийн хичээлийн оёдлын машины чанар муу, амархан эвдэрч ашиглагдахгүй /5-р сургуульд ирсэн 8 оёдлын машины 7-нь ашиглагдахгүй/ болсон гэх мэт олон олон асуудлыг багш нар ярьж, харуулж байв.

Физикийн хичээлийн 86 нэр төрлийн 39.9 сая төгрөгийн хэрэглэгдэхүүн ирсэн бөгөөд үүнд нэг бүр нь 2.0 сая төгрөгийн үнэ бүхий дижитал осциллоскоп 1 ширхэг, нэг бүр нь 920.4 мянган төгрөгийн сэргээгдэх эрчим хүчний туршилтын 5.5 сая төгрөгийн иж бүрдэл 6 ширхэг, 888.1 мянган төгрөгийн хөдөлгөөн мэдрэгч, бүртгэгч 1 ширхэг гэх мэт өнөдр үнэ бүхий багаж хэрэгсэл байна. Кабинетаар хичээллэхгүй байгаагаас шалтгаалж багш хэрэглэгдэхүүнийг ангиудын хооронд зөөх, цөөн тоогоор хэрэглэж байна.

Хөрөнгө оруулалтаар нийлүүлэх тоног төхөөрөмжийн ашиглагдах орчин, түүнийг ажиллуулах, ашиглах багш нарын мэдлэг чадвар, бүтээлч идэвх санаачлага, сургуулийн хэрэгцээ шаардлагыг оновчтой судлаагүй байна. Сургуулиудад химийн дадлага хичээлд ашиглагдах урвалж бодисыг /сорох шүүгээг угсрах агааржуулалтын хоолой/ гадагш нь хоолойгоор гаргах орчин бүрдээгүй байна.

Нийлүүлэгдсэн хөрөнгийн үнэ хэт өндөр байгаагаас шалтгаалж багш нар тухайн хэрэглэгдэхүүнийг эвдрэх, алга болгох, дутаах, төлбөрт орохоос айж хичээлд хэрэглэхгүй хадгалдаг, хүүхэд бүрт ашиглуулдаггүй байдалтай байна.

Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалж сургалтын хөтөлбөрийн дагуу хичээл орохгүй, ажиглалт, туршилтаар сурагчдын олж авах мэдлэг, ойлголт, сурах хүсэл сонирхол, бүтээлч, шинжлэх ухаанч арга барил эзэмшиж чадахгүйд хүрч сурлагын чанарт нөлөөлж байна.

Хөрөнгө, техник, хэрэглэгдэхүүнийг ашиглахгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үнэ цэнэ, үр өгөөжийг бууруулж байна.

А.2.3 Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалттай эсэх

Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ дутмагаас суралцагч эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмших боломжгүй болох үр дагавартай байна.

- Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалттай байна уу? /багш, нийгмийн ажилтан, номын санч, багш нар мэргэжлээрээ ажиллаагүй байх/

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д “Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна” гэж заасан. Аймгийн хэмжээний ЕБС-д 2017-2019 онд дунджаар 623 багш, 21 захирал, 36 сургалтын менежер, 18 нийгмийн ажилтан, 17 номын санч ажилласан байна.

Аудитад хамрагдсан Алтанширээ суманд МСҮТ-ийг хөгжимчин мэргэжлээр төгссөн хүн хөгжмийн багшаар, Хөвсгөл суманд МУБИС-ийн 4-р курсийн оюутан биеийн тамирын багшаар, багш мэргэжилгүй хүн биологийн багшаар тус тус ажиллаж байв.

Сургалтын хөтөлбөрийн дагуу нэг багш 7 хоногт 19 цагийн хичээл заана. Зарим сумын сургуульд анги, бүлгийн тоо цөөн байгаагаас шалтгаалж хичээл заах нормативт цаг хүрээгүй тохиолдолд өөрийн мэргэжлийн бус 2-3 хичээлийг давхар заах тохиолдол гарч байна.

Хүснэгт №3. Мэргэжлийн бус багш, номын санч

№	Сургууль	Мэргэжлийн бус хичээл заадаг	Мэргэжлийн номын санчтай эсэх
1	Сайншанд ЕБ-ын 1 дүгээр сургууль		Тийм
2	Сайншанд ЕБ-ын 2 дугаар сургууль		Тийм
3	Сайншанд ЕБ-ын 3 дугаар сургууль		Тийм
4	Сайншанд ЕБ-ын 5 дугаар сургууль	МХУЗ-ын багш бага ангийн багшаар	Үгүй
5	Сайншанд сумын Зүүнбаян сургууль	Газарзүйн багш бага ангийн багшаар	Үгүй
6	Замын-Үүд ЕБ-ын 1 дүгээр сургууль		Тийм
7	Замын-Үүд ЕБ-ын 2 дугаар сургууль	Математикийн багш бага ангийн багшаар	Тийм
8	Замын-Үүд ЕБ-ын 3 дугаар сургууль		Үгүй
9	Алтанширээ сумын ЕБ-ын сургууль	Биологийн багш хими давхар заадаг.	Үгүй
10	Дэлгэрэх сумын ЕБ-ын сургууль	Биологийн багш хими, Нийгмийн багш түүх	Үгүй
11	Улаанбадрах сумын ЕБ-ын сургууль	Физикийн багш математикийн хичээл	Үгүй
12	Хатанбулаг сумын ЕБ-ын сургууль	Математикийн багш физикийн хичээл давхар заадаг.	Үгүй
13	Хөвсгөл сумын ерөнхий боловсролын сургууль	Нийгэм, газарзүйн багш бага ангийн багшаар, технологийн багш дүрслэх урлаг, мэдээлэл зүйн хичээл, нийгмийн ухааны багш нь газар зүй, хүн нийгэм, иргэний боловсролын хичээл давхар заасан	Үгүй

Хатанбулаг, Хөвсгөл суманд хими, физик, Алтанширээ суманд физикийн хичээл заах багшгүйгээс хөтөлбөрийн дагуу хичээл ороогүй байна.

Нийгмийн ажилтнаар ажиллаж буй 18 хүний 11 нь багш мэргэжилтэй, 7 нь нийгмийн ажилтны мэргэжлээр бакалаврын зэрэгтэй байна.

Номын санчаар ажиллаж буй 17 хүний 6 нь мэргэжлийн бөгөөд мэргэжлийн бус хүн ажиллуулсан Айраг, Даланжаргалан, Дэлгэрэх, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ, Замын-Үүд сумын II, III сургууль, Сайншанд сумын V сургууль байна. Аудитад хамрагдсан 13 сургуулийн 5 сургуульд мэргэжлийн номын санч ажиллаж байна.

Сумын орон нутгийн дэд бүтэц, хөгжил, амьдрах орчин зэрэг асуудлаас шалтгаалж залуу багш, ажилчид тогтвор суурьшилтай ажилладаггүй, багш мэргэжлээр төгссөн хүмүүс хөдөө сургуульд ажиллах сонирхолгүй байгаа нь сургуульд багш, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээгүй байдлыг бий болгож байна.

Сургуулиудад мэргэжлийн багш, номын санч нийгмийн ажилтан дутагдалтайгаас мэргэжлийн бус хүн ажилласан нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх, суралцагч эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмших боломжгүй болох үр дагавартай байна.

- Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж байна уу?

Дорноговь аймгийн ИТХ-ын 2017 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан "Маргаашийн нар багшийн гар дээр мандана" дэд хөтөлбөрийн хүрээнд сургууль бүр багшийг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаж батлуулан хэрэгжилтийг тайлагнасан байна.

Аймгийн хэмжээнд багшийг хөгжүүлэх дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- 2017-2019 онд 48 багш удирдах ажилтан ОХУ, ӨМӨЗО, Япон, Солонгос, АНУ-д туршлага судалж, давхардсан тоогоор 2500 гаруй багш удирдах ажилтныг мэргэжил дээшлүүлэх 46 удаагийн сургалтад хамруулсан байна.
- "Маргаашийн нар багшийн гар дээр мандана" дэд хөтөлбөрийн хүрээнд Дорноговь аймгийн ЕБС-уудыг хамруулан Бага ангийн багш нарыг бие биеэсээ

суралцуулах зорилгоор “Зочин багш” үйл ажиллагааг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.

“Хөгжлийн төлөө хамтдаа” Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.8 дахь зорилтын хэрэгжилтийг хангах “багш чадваржуулах хөтөлбөр”-ийн хүрээнд Улаанбаатар хотын Шинэ Монгол сургуультай хамтарч 2017-2019 онд багш нарыг чадваржуулах, сурлагын чанарыг ахиулах, элсэлтийн ерөнхий шалгалтад амжилт үзүүлэх зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. Хамтын ажиллагааны хүрээнд:

- 2017 онд 16 багшийг урьж 145 багшид сургалт зохион байгуулсан.
- 2018 онд Шинэ Монгол сургуулийн багш нар “ЭЕШ-нд бэлтгэх арга зүй, сургуулийн менежментийг сайжруулах сургалт зохион байгуулж 130 багш хамрагдсан.
- 2018 онд Улаанбаатар хотноо математикийн 31 багшийг сургалтад хамруулсан байна.
- 2019 онд 4 сургуулийн 230 гаруй багшид ЭЕШ-ийн 10 хичээлээр арга зүйн зөвлөгөө өгч чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна.

Хүснэгт №4. Мэргэжил дээшлүүлсэн багш /давхардсан тоогоор/

Огноо	Үндсэн сургалт		Төрөлжсөн сургалт	Ажлын байран дахь сургалт
	БМДИ	БСУГ		
2017	37	1653	35	318
2018	40	1172	205	156
2019	24	822	679	152

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3⁷-т заасны дагуу ЕБС бүр “Багшийн хөгжлийн төв”-тэй байх заалтын хүрээнд:

2017-2019 оны байдлаар 13 сургуулийн 10 буюу 76,9% нь багшийн өрөөг тохижуулж “Багш хөгжүүлэх төв”-тэй болсон хэдий ч батлагдсан төсөв мөнгөгүйгээс үйл ажиллагааны төлөвлөгөө тайлан боловсруулж бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор багш нарыг сургалт, үр чадварын тэмцээнд хамруулах, биесээсээ суралцах сурах, боловсрох, хөгжүүлэх нөхцөл бололцоогоор хангаж үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулжээ. Харин ТБӨ-ийн зарим ЕБС багш нарыг сургалтад хамруулаагүй, хөгжлийн төв байгуулаагүй зэргээр хөгжих нөхцөл, боломжийг нь хангаж ажиллаагүй байна.

- "Сургуулийн захирал, эрхлэгч, менежер, багш холбогдох шалгуурт нийцэж байна уу? /Ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур хангахгүй байх, үндсэн багш багшлах эрхгүй байх/"

Аудитад хамрагдсан ЕБС-аас ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур хангаагүй 3 багш ажиллаж байна. Тухайлбал:

- Алтанширээ сумын ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн хөгжмийн ангийг 2,5 жилээр суралцаж төгссөн хөгжимчин мэргэжилтэй ба 2020 онд Газарчин дээд сургуулийн дуу хөгжмийн багшийн ангид сурч байна.

⁷ 3.1.3. “багшийн хөгжлийн төв” гэж багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжихөд шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж бүхий орчинг;

- Хөвсгөл сумын ерөнхий боловсролын сургуульд биеийн тамирын багш сургуулиа төгсөөгүй 4 дүгээр курсын оюутан ажиллаж байна.
- Мөн химийн багшийг сумын зүгээс төлбөрийг нь дааж их сургуульд сургасан ба сургуулиа төгсөөгүй, дипломоо авч чадаагүй ч багшилж байгаад хүүхдээ асрах чөлөөтэй байна.
- "Салбарын яам ЕБС-ын хүний нөөцийн бодлого оновчгүй, бодлогын хэрэгжилт үр дүнтэй байна уу? /БСШУСЯ-ны дээд боловсролын бодлогын газар, мөшгөх судалгаа, Боловсролын газрын зүгээс багшийн эрэлт, хэрэгцээний талаар судалгаа хийж, санал дэвшүүлж байсан эсэх/

БСУГ-аас ЕБС-д ойрын 5 жилд дутагдах багшийн судалгааг гарган ажиллаж байна.

Хүснэгт №5. Ойрын 5 жилд дутагдах багшийн судалгаа

№	Хичээлийн нэр	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022
1	Бага анги	17	8		3	1
2	Монгол хэл	2	1	2		1
3	Англи орос хэл	4	2	2		1
4	Математик	5	4	1		
5	Физик Мэдээлэл зүй	1		1	1	
6	Дуу хөгжим	3	3			
7	биеийн тамир	2				
8	Түүх Газарзүй	2			1	
9	Технологи	4	4	1	1	
10	Хими биологи		2		1	1
Нийт	82	40	24	7	7	4

- "Салбарын яам ЕБС-ын хүний нөөцийн бодлого оновчгүй, бодлогын хэрэгжилт үр дүнтэй байна уу? /тэгш хүрэлцээ/

БСУГ-аас ЕБС-д ойрын 5 жилд дутагдах багшийн судалгааг гарган ажиллаж байна.

Дээрх нөхцөл байдал нь анги бүлгийн тоо хэт цөөн буюу багшийн 7 хоногт хичээллэх цагийн норм 19 цагтаа хүрдэггүй, суманд ажиллах багш олддоггүйтэй холбоотой байна.

А.3 Бүх нийтийн ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилтийг бодитой төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж байгаа эсэх

Төсвийн төлөвлөлтийг боловсруулах, төсөв батлах, хуваарилах, зарцуулах, хяналт тавих үйл явц хуулийн хүрээнд хангалттай хэрэгжээгүй, төсвийн сахилга бат алдагдаж байна.

А.3.1 Төсвийг бодитой төлөвлөж, үр ашигтай хуваарилж буй эсэх

Төсвийн төлөвлөлт, хуваарилалтын оновчгүй байдлаас шалтгаалж төсөвт олон удаа өөрчлөлт оруулсан, төсвийн зарчим, үр ашигт байдлыг хангаж ажиллаагүй байна.

- Төрөөс сургуулиудад олгож буй хувьсах зардлыг онцлог, хэв шинжтэй уялдуулан бодитой төлөвлөж байна уу?

Дорноговь аймгийн ерөнхий боловсролын 22 сургуульд 2016-2017, 2017-2018, 2018-2019 оны хичээлийн жилүүдэд дунджаар 12664 сурагчтайгаар, 1052 багш, ажиллагсад ажилласан байна.

Бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээг дараах хөтөлбөрүүдээр ангилж төсвийн төслийг 2017 онд 18.3 тэрбум төгрөг, 2018 онд 18.7 тэрбум төгрөг, 2019 онд 19.3 тэрбум төгрөгөөр боловсруулж хүргүүлсэн байна.

Хүснэгт №6. Төсвийн төсөл

	Үйлчилгээ	2017 оны төсвийн төсөл		2018 оны төсвийн төсөл		2019 оны төсвийн төсөл	
		Хүүхдийн тоо	дүн	Хүүхдийн тоо	дүн	Хүүхдийн тоо	дүн
1	Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх	13903	8140,9	13421	9523,4	13449	8394,8
2	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах		6561,1		6264,8		7339,1
3	Дотуур байрны үйлчилгээ	1047	1351,7	1055	1353,7	1830	1627,9
4	Үдийн цай хөтөлбөр	8036	757,4	8439	758,3	7176	732,9
5	Ажил олгогчоос төлөх тэтгэмж		1150,0		419,9		932,7
6	Дүйцсэн хөтөлбөрөөр албан бус боловсрол олгох үйлчилгээ		42,9		43,0		
7	Төрийн бус байгууллагад төрөөс олгох дэмжлэг	245	286,5	245	338,7	294	288,2
	Төсвийн төслийн нийт дүн		18290,5		18701,8		19316,0

Төсвийн төсөл боловсруулахдаа Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, дотуур байрны үйлчилгээ, төрийн бус байгууллагад төрөөс олгох дэмжлэг гэсэн үйлчилгээнд хувьсах зардлын дундаж нормативыг баримтлан төсөвлөсөн байна. Сангийн яамнаас хүүхдийн дундаж тоог 2017 онд 1384-өөр, 2018 онд 180-аар, 2019 онд 644-өөр тус тус хүүхдийн тоог бууруулж төсөв хянасан байна.

Хүснэгт №7. Сангийн яамны хянасан төсөв

Үзүүлэлт	2017		2018		2019	
	Хүүхдийн тоо	Дүн	Хүүхдийн тоо	Дүн	Хүүхдийн тоо	Дүн
ТЕЗ-ийн төсвийн төсөл	14148	18,290.5	13666	18,701.5	13449	19,316.0
УИХ-д өргөн барьсан төсөл		16,088.1		17,269.3		16,453.0
ТЕЗ, УИХ-д өргөн барьсан төслийн зөрүү		2202.4		1432.2		2863.0
СЯ-наас хянасан	12764	15,872.8	13486	17,269.3	12805	16,453.0
ТЕЗ, СЯ-ны хянасан төсвийн зөрүү	1384	2417.7	180	1432.2	644	2863.0

Хичээлийн жил, төсвийн жил тохирдоггүйтэй холбоотойгоор жилийн зардлыг төлөвлөхдөө тухайн оны 1-6 дугаар сарын хүүхдийн тоог урьд оны 9 дүгээр сард сургуулиудын гаргасан статистик тайлан мэдээгээр, харин 9-12 дугаар сарын хүүхдийн тоог суралцах хүүхдийн тооны прогноз хэлбэрээр тооцож дунджийг гарган хүүхдийн тоог төлөвлөдөг байна. Сангийн яамнаас төсөв хянахдаа 10, 11 дүгээр сарын статистик мэдээгээр бодит хүүхдийн дундаж тоонд үндэслэн хянадаг зэргээс хүүхдийн тоо зөрдөг байна.

Төсвийн төсөл боловсруулахдаа Засгийн газрын 2014 оны 208 дугаар тогтоол, 2014 оны 332 дугаар тогтоол, 2018 оны 264 дүгээр тогтоол, 2019 оны 24 дүгээр тогтоолоор баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээгээр орон тооны багш нарын үндсэн цалинг бодож **тооцсон цалинг** гаргасан ба түүн дээр нэмэгдэл цалинг нэмж цалингийн төсвийн төслийг боловсруулсан байна. Энэхүү цалингийн зардлын дүнгээс НДШ-ийн зардлыг 11 хувиар тооцжээ. ЗГ-ын дээрх тогтоолуудаар цалингийн хэмжээ нэмэгдэж шинэчлэгдсэн байхад 2016 онд тогтоосон хувьсах зардлын норматив өнөөгийн нөхцөлд тохирохгүй болсон байна.

МУ-ын Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын аргачлалын 3.1-д “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын албан сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын бараа, үйлчилгээний бусад хувьсах зардалд эзлэх хувь хэмжээг төсвийн шууд захирагчийн саналыг үндэслэн төсвийн төвлөрүүлэн захирагч, төвлөрүүлэн захирагчийн саналыг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч боловсруулна” гэж заасан байна.

Бараа үйлчилгээний бусад хувьсах зардлын дүнд эзлэх хувийг 12 жилийн сургалттай сургуульд шуудан холбооны зардлыг илүү, 9 жилийн сургалттай сургуульд томилолтын зардал, БҮТЭЗ-ийн зардлыг илүү тооцсон байна. 2017 онд бараа үйлчилгээний бусад зардлуудын хувийг бичиг хэрэг 6.0 хувь, хичээл үйлдвэрлэлийн зардал 52.4 хувь, ном хэвлэлийн зардал 2.9 хувь, шуудан холбоо 4.5 хувь, томилолт 4 хувь, БҮТЭЗ 12.2 хувь, нормын хувцас, зөөлөн эдлэл 10 хувь, эм бэлдмэл 2.0 хувь, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчийн устгал, ариутгал 2 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж 4 хувиар тус тус тооцож төсвийн төсөл боловсруулсан байна.

Хувьсах зардлын дундаж нормативыг баримтлан бараа үйлчилгээний бусад хувьсах зардлыг тооцсон ба бараа, үйлчилгээний бусад хувьсах зардалд эзлэх хувь хэмжээг санал харгалзахгүйгээр ТЕЗ тогтоож жил бүр хувь хэмжээг өөрчилж боловсруулсан байна.

Сургуулиудын төсөв байршил болон бусад хүчин зүйлээс үл хамааран хуваарилсан ба сургуулийн хүчин чадал, багш ажилтны тоо зэрэгтэй холбоотойгоор сургуулиудын төсөв харилцан адилгүй байна.

- Төсвийн хуваарилалт оновчтой, тэгш хүртээмжтэй байна уу?

Сангийн яамнаас ерөнхий боловсролын сургуулийн төсвийг хянаж ирүүлэхдээ ТЕЗ-ийн хүргүүлсэн төсвийн төсөл дэх хүүхдийн тооноос хасаж тооцож ирүүлсэн бөгөөд төсөвт өөрчлөлт орсон тухай бүр Аймгийн ИТХ-аас 2017 онд 2 удаа, 2018 онд 1 удаа 2019 онд 2 удаа тус тус өөрчлөлт оруулж төсөв баталсан байна. Хүснэгт №8.

1. 2017 ОНЫ ЕБС-ИЙН ТӨСӨВ				
Тусгай зориулалтын шилжүүлэг ЕБС	2017 оны төсөв	тодотгол	тодотгол	2017 оны төсөв
	АИТХ-ын 2016.12.05 03/05 тогтоол	АИТХ-ын 2017.05.30 04/02 тогтоолоор өөрчилсөн дүн	АИТХ-ын 2017.12.01 06/01 тогтоолоор өөрчилсөн дүн	
Дүн	15,680,218.5	-	4,345.0	257,426.5
				15,933,300.0

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ЕБС-ийн 2017 оны төсвийг 2 удаа өөрчлөхдөө зардал хооронд болон сургуулиудын хооронд 1274.2 сая төгрөгийн нэмэгдүүлэх,

1021.1 сая төгрөгийн бууруулах өөрчлөлт оруулж нийт дүнгээр 253.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Хүснэгт №9.

2. 2018 ОНЫ ЕБС-ИЙН ТӨСӨВ			
Тусгай зориулалтын шилжүүлэг ЕБС	2018 оны төсөв	2017 оны төсөв	2018 оны төсөв
	АИТХ-ын 2017.12.01 06/02 тогтоол	АИТХ-ын 2018.12.03 09/07 тогтоолоор өөрчилсөн дүн	
Дүн	17,103,991.5	- 407,629.0	16,696,362.5

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ЕБС-ийн 2018 оны төсвийг 1 удаа өөрчлөхдөө зардал хооронд болон сургуулиудын хооронд 1702.8 сая төгрөгийн нэмэгдүүлэх, 2110.4 сая төгрөгийн бууруулах өөрчлөлт оруулж нийт дүнгээр 407.6 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны А/595, А/769 дүгээр захирамжаар төсөвт 1274.2 сая төгрөгийн нэмэгдүүлэх өөрчлөлт, 1021.1 сая төгрөгийн бууруулах өөрчлөлт, нийт дүнгээр 253.1 сая төгрөгийн нэмэгдүүлэх өөрчлөлт хийсэн бөгөөд жилийн эцэст аймгийн ИТХ-аар тодотгон батлуулах төсөвт энэхүү өөрчлөлтийг хамт оруулжээ. Хүснэгт №10.

3. 2019 ОНЫ ЕБС-ИЙН ТӨСӨВ				
Тусгай зориулалтын шилжүүлэг ЕБС	2019 оны	тодотгол	тодотгол	2019 оны төсөв
	АИТХ-ын 2018.12.03 09/08 тогтоол	АИТХ-ын 2019.06.10 11/09 тогтоол	АИТХ-ын 2019.12.04 12/07 тогтоол	
Нийт дүн	16,453,013.8	зардал хооронд 181.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, бууруулж өөрчлөлт оруулсан	- 519,254.9	15,933,758.9
Үүнээс орон нутгийн төсвөөс санхүүжих тогтмол зардал, урсгал засварын дүн	2,973,877.2	-	-	2,973,877.2

Аймгийн ИТХ-ын тогтоолоор ЕБС-ийн 2019 оны төсвийг 2 удаа өөрчлөхдөө зардал хооронд болон сургуулиудын хооронд 854.0 сая төгрөгийн нэмэгдүүлэх, 1373.3 сая төгрөгийн бууруулах өөрчлөлт оруулж нийт дүнгээр 519.3 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Хүснэгт №11

ЗАРДЛЫН ДҮНД ОРУУЛСАН ӨӨРЧЛӨЛТ					
	Зардлын эдийн засгийн ангилал	2017 он	2018 он	2019 он	3 жилийн дүн
1	Цалин хөлс	- 155,245.7	215,922.9	- 932,245.8	- 871,568.6
2	Ажил олгогчоос олгох шимгэл	- 29,556.4	93,567.0	- 116,393.7	- 52,383.1
3	Гэрэл цахилгаан	- 103,368.6	- 133,690.1	-	- 237,058.7
4	Түлш халаалт	- 394,763.9	- 558,886.5	-	- 953,650.4
5	Цэвэр бохир ус	- 74,919.4	- 125,497.6	-	- 200,417.0
6	Бичиг хэрэг	300.0	3,255.6	1,645.2	5,200.8
7	Тээвэр шатахуун	3,760.0	5,960.2	14,714.0	24,434.2
8	Шуудан холбоо	2,009.0	1,981.7	493.8	521.1
9	Ном хэвлэл	-	78.1	- 250.0	- 171.9
10	Хог хаягдал ариутгал	100.0	2,705.2	8,471.5	11,276.7
11	БҮТЭЭ	211,864.8	18,940.6	25,609.4	256,414.8
12	эм хэрэгсэл	-	-	5,000.0	5,000.0
13	Хоол хүнс	- 183,983.3	- 197,805.6	- 204,698.0	- 586,486.9
14	Нормын хувцас зөөлөн эдлэл	10,600.0	14,153.0	639.1	25,392.1
15	Эд хогшил, урсгал засвар	679,874.8	1,268,097.0	583,384.0	2,531,355.8
16	Албан томилолт	3,202.2	5,242.7	- 36,573.9	- 28,129.0
17	БГАУТ	7,041.9	4,216.0	2,158.9	13,416.8
18	БУБЗ	-	- 325.2	400.0	74.8
19	Хичээл үйлдвэрлэл дадлага хийх	12,470.0	70,628.2	211,526.7	294,624.9
21	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж /УЦХ/	- 62,132.0	- 10,271.9	- 83,136.1	- 155,540.0
22	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	343,027.1	- 759,071.4	-	- 416,044.3
23	Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан	- 17,138.8	- 2,165.0	-	- 19,303.8
24	Тэтгэмж урамшуулал	-	- 320,700.0	-	- 320,700.0
	Дүн	253,141.7	- 407,628.5	- 519,254.9	- 673,741.7

Батлагдсан төсвийн өөрчлөлт 3 жилийн дүнгээр 673.7 сая төгрөгөөр бууруулсан ба цалин, НДШ, тогтмол зардлууд, албан томилолт, хоолны зардал, үдийн цай хөтөлбөрийн зардлуудын төсөв илүү тооцогдсон байна.

Сургуулиудын төсвийн санхүүжилтийн дүнд аймгийн Санхүү хэлтэс гэсэн нэр дээр Сайншанд суманд шинээр баригдах 320 хүүхдийн бага сургуулийн урсгал зардалд 2017 онд 369.4 сая төгрөг, 2018 онд 1,607.5 сая төгрөг, нийт 1,976.9 сая төгрөгийн төсвийг аймгийн ИТХ-аар батлуулж, зарцуулжээ. УИХ-аас 2018-2019 онд барилгыг барьж дуусган ашиглалтад оруулахаар төсөв батлагдсан байна. Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад дээрх сургуулийн нийт төсөвт өртөг 2.1 тэрбум төгрөг байсан байна.

Сургуулиудын эд хогшил, урсгал засварын төсвийг нийт 2531.4 сая төгрөгөөр аймгийн ИТХ-аас нэмэгдүүлж баталсан байна. Сургуулийн хичээлийн байрны дээврийн засвар, шат, ОО-ын засвар, дотор халаалт, гэрэлтүүлэг, уурын зуухны шугам сүлжээ, гадна дулааны шугам шинэчлэлийн ажил, багшийн хөгжлийн төвийн засварт дотуур байрны засвар, хүүхэд хөгжлийн төвийн ширээ, сандал, зөөлөн эдлэл, камержуулалт, хөгжмийн зэмсэг авах компьютер, самбар, тоног төхөөрөмж, технологийн кабинетын засвар зэрэгт төсөв баталж зарцуулсан байна.

Шинээр ашиглалтад орох сургуулийн төсвөөс дараах байгууллагуудын цалин, НДШ, түлш халаалтын зардалд 231,3 сая төгрөгийг хуваарилан зарцуулжээ. Үүнд: Биеийн тамир спортын газарт 146.3 сая төгрөг, аймгийн Номын санд 7.0 сая төгрөг, Саран хөхөө театрт 13.2 сая төгрөг, сумдын Соёлын төвүүдэд 64.8 сая төгрөг байна.

Төсвийн тухай хуулийн 6.6.4-т “төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх” гэсэн заалтыг зөрчиж шинэ сургуулийн урсгал зардалд зориулагдсан төсвөөр бусад сургууль, боловсролын салбарын байгууллагуудын урсгал зардалд зарцуулсан байна.

Төсвийн хуваарилалт тэгш хүртээмжтэй бус, дараа онд ашиглалтад орох бага сургуулийн урсгал зардлыг илүү төлөвлөн батлуулж зарцуулсан, төсвийн төлөвлөлтөд тавих хяналт сул байгаагаас төсөвт олон удаа өөрчлөлт оруулж төсвийн зарчим, үр ашигт байдлыг хангаж ажиллаагүй байна.

- "Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийг үндэслэлгүй төлөвлөсөн үү? /зарим дотуур байр 6 настай хүүхэд амьдардаг дотуур байраар тооцож хувьсах зардлыг өндөр авсан байх/"

МУ-ын Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 4-р хавсралтаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ”-г 6 настай хүүхэд амьдрах дотуур байр, дотуур байр гэсэн хэв шинжээр баталсан. Сургуулиудын 16 дотуур байранд 2017-2018 оны хичээлийн жил, 2018-2019 оны хичээлийн жилд амьдарсан хүүхдийн дундаж тоо 799 байгаа бөгөөд 2018 оны санхүүгийн жилийн төсвийн төсөлд тооцсон хүүхдийн тоо 1054 байгаа нь 255 хүүхдээр илүү төлөвлөсөн байна. Энэ нь дотуур байранд амьдрах хүүхдийн тоог байрны хүчин чадлын үзүүлэлтээр тооцож төлөвлөсөнтэй холбоотой байна. Тодруулбал сургуулиудын нийт дотуур байрны хүчин чадал 1154 бөгөөд статистик мэдээгээр 785-813 хүүхэд дотуур байранд амьдарсан байна.

Төсвийн төслийг 6 настай хүүхдийн дундаж тоо, 6-аас дээш настай хүүхдийн дундаж тоонд үндэслэн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээгээр боловсруулсан байна.

Хүснэгт №12. Дотуур байрны хувьсах зардал

		Хүүхдийн тоо.	Нормативаар тооцсон хоолны зардал /сая.төг/	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
	2016-2017 оны хичээлийн жил	856	485.5	438.7	363.0
	2017-2018 оны хичээлийн жил	813	458.3	473.2	369.9
	2018-2019 оны хичээлийн жил	785	407.1	365.1	356.5

ЕБС-ийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тооцохдоо 6-аас дээш насны суралцагчийн хувьсах зардлыг 6 настайгаар тооцсон зөрчил гаргаагүй, хүүхдийн хоолны мөнгийг нэг суралцагчид 2315 төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

Хоолны зардлын төсвийг аймгийн ИТХ-аас 2017 онд 184.0 сая төгрөгөөр, 2018 онд 197.8 сая төгрөгөөр, 2019 онд 204.7 сая төгрөгөөр бууруулж тодотгон баталснаас харахад хувьсах зардлын нормативын хэмжээ оновчгүй, хүүхдийн тоог бодитой тооцоогүйгээс сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

- Ном, сурах бичигт шаардлагатай хөрөнгийг бодитой тооцож төлөвлөсөн үү?

Сургуулиудад хэрэглэгдэх ном, сурах бичгийн хөрөнгийг тооцох, төлөвлөх асуудлыг БСШУЯ хэрэгжүүлдэг байна. БСУГ тухайн хичээлийн жилд шаардлагатай ном, сурах бичгийн судалгааг гарган, нэгтгэж салбарын яаманд хүргүүлдэг байна. Иймд сурах бичигтэй холбоотой хөрөнгийн төлөвлөлт, тооцооллыг хийдэггүй, зөвхөн ном, хэвлэлийн зардлын төсвийг төсөвлөдөг байна.

Бага, дунд боловсролын статистик мэдээгээр сургуулиудын сурах бичгийн хангалт хичээлийн жилүүдэд нийт ангиудын дундаж дүнгээр 32.2- 36.2 хувь дутагдалтай байсан үзүүлэлттэй байна. 2016-2017 оны хичээлийн жилд ахлах ангийн сурагчдын 64.6 хувь, дунд ангийн сурагчдын 40 хувь, бага ангийн сурагчдын 2.2 хувь нь сурах бичгээр хангагдаагүй байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд ахлах ангийн сурагчдын 60.9 хувь, дунд ангийн сурагчдын 46.1 хувь, бага ангийн сурагчдын 0.2 хувь нь сурах бичгээр хангагдаагүй үзүүлэлттэй байна.

Хүснэгт №13. Сурах бичгийн судалгаа

Үзүүлэлт		2016-2017	2017-2018	2018-2019
Бага	Нийт сурагчдын тоо	44016	46931	49369
	Дутагдалтай	976	594	90
	Сурагч өөрөө	57	20	53
дунд	Нийт сурагчдын тоо	57537	61803	64075
	Дутагдалтай	23852	30109	29555
	Сурагч өөрөө	10682	9579	19553
ахлах	Нийт сурагчдын тоо	24390	23776	19826
	Дутагдалтай	15748	17227	12077
	Сурагч өөрөө	1603	5801	5311
Нийт дүн	Нийт сурагчдын тоо	125943	132510	133270
	Дутагдалтай	40576	47930	41722
	Сурагч өөрөө	12342	10347	24917

- Шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний төсөв бодитой төлөвлөж байна уу? /нас, онцлогт тохирсон, хүрэлцээтэй эсэх/

Бараа, үйлчилгээний бусад хувьсах зардлын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын норматив аймгийн төвөөс бусад сумын 9 жилийн сургуульд 21.9 мянган төгрөг, 12 жилийн сургууль 14.6 мянган төгрөг, аймгийн төвийн сургуульд 13.9 мянган

төгрөгөөр тогтоосон. Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал дахь 10 нэр төрлийн зардлын эзлэх хувь хэмжээг ТШЗ-ийн санал харгалзахгүйгээр тогтоож жил бүр өөрчилж байгаагаас бараа үйлчилгээний бусад хувьсах зардал, хичээл үйлдвэрлэлийн зардал бодитой төлөвлөгдөхгүй байна. Тодруулбал: Аймгийн ИТХ-аас хичээл үйлдвэрлэлийн зардлын төсвийг 2017 онд 12.5 сая төгрөгөөр, 2018 онд 70.6 сая төгрөгөөр, 2019 онд 211.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тодотгон баталсан байна.

Сургалтын хэрэглэгдэхүүний төсөв хүрэлцээгүйгээс гарын авлага, сургалтын үзүүлэнг багш нар өөрсдөө хийдэг, эмэгтэй, эрэгтэй технологийн хичээлд хоолны болон самбарын шугам, гар багаж, цахилгаан багаж дутагдалтай, электрон хичээлийн хэрэглэгдэхүүнгүй, цөм, сайжруулсан хөтөлбөрт тусгагдсан гоо зүйн хичээл орох хэрэгсэл байдаггүй, хичээлд дадлага хийх материалыг эцэг эхээс гаргуулдаг, физикийн хичээлээр үзүүлэх сургалтын багажтай, хүүхдүүд ажиллахад хүрэлцээгүй байдаг байна.

А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж байгаа эсэх

Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг хянаагүй, төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй байна.

- Санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, цаг тухайд нь бүрэн олгоогүй байх

МУ-ын Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолын 6-р хавсралт “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 3.12-т “Сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно” гэж заасан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийг санхүүжилт орсон дүнгээр буюу төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу тухай бүр шилжүүлсэн ба хүүхэд өдрөөр бүрэн хянаж санхүүжүүлдэггүй байна.

Төсвийн тухай хуулийн 45.2.-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1. “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж хүүхдийн хоолны зардлын төсвийн хэмнэлт 586.5 сая төгрөгийг дансанд төвлөрүүлээгүй бусад сургууль, зардал хооронд гүйлгэн шилжүүлж зарцуулсан байна.

- Ном, сурах бичгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?

Сургуулиудад ном хэвлэлийн зардалд нийт 28.8 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 52.3 сая төгрөгийг зарцуулсан байна. Ном хэвлэлийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

- "Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулж буй хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулж байна уу?

Багшийн хөгжлийг дэмжих зардлыг хувьсах зардлын дүнгийн 2 хувиар тооцож төсөвлөсөн ч багшийн хөгжлийг дэмжих зардлын төсөв батлагдаж ирээгүй байна. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас багш нарын зарим сургалтын зардал, техник хэрэгсэлд хөрөнгө зарцуулсан байна. Багшийн хөгжлийг дэмжих сургалтыг үндэсний, бүсийн, орон нутгийн түвшинд жил бүр зохион байгуулдаг ч сумдын багш нарыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, зардал хүрэлцдэггүй байна.

- Төрийн сан, боловсролын газраас хувьсах зардал олголтод үр нөлөөтэй хяналт тавьж санхүүжүүлдэг үү?

Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлт, илэрсэн зөрчлийн судалгааны дүнгээс харахад хязгаарлалттай дүгнэлт авсан сургууль 2017 онд 3, 2018 онд 2, 2019 онд 12 сургууль байгаа бөгөөд аудитаар нийт 1304.4 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн байна. Эдгээр зөрчлийн 36.3 хувь нь нягтлан бодох бүртгэл, тайлагналтай, 1.8 хувь нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй, 9.1 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилт, 21.8 хувь нь дотоод хяналттай, 31.0 хувь нь худалдан авалттай холбоотой зөрчил байна.

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлж төсвийг бодитой төлөвлөж, үр ашигтай хуваарилаагүй, арвилан хэмнэлтгүй, хяналтгүй зарцуулсан байна.

- Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хүүхэд өдрөөр тооцож олгодог уу?

Тендерт шалгарч гэрээ байгуулсан компаниудад үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтийг олгохдоо сургуулиуд тухайн сард хичээлд ирсэн хүүхдийн тоогоор тооцож хүнсний бүтээгдэхүүнийг хүлээн авсан баримт материалд үндэслэн сар тутамд шилжүүлсэн байна.

Сургуулиуд өдөрт 600 төгрөгөөр тооцож үдийн цайны цэсийг 7-14 хоногоор зохиож батлуулан мөрдөж ажиллажээ. Өөрөөр хэлбэл нэг хүүхдэд өдөрт 600 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн олгож, тухайн сарын гүйцэтгэлийг үндэслэн нийлүүлэгч компанид санхүүжилт олгожээ. 2017-2018 оны хичээлийн жилийн хүүхдийн ирцийн дүнд 62.1 сая төгрөг хэмнэгдсэнийг цалингийн зардалд шилжүүлэн аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор тодотгосон байна.

Нийт 12 сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг үзэхдээ 2017, 2018 оны хичээл орсон сар бүрийн 10-12-ны өдрийг сонгож багш нарын журнал дахь хүүхдийн ирцийг шаардахаар зарлагадсан тоотой, эд хариуцагчийн тухай сарын бэлтгэн нийлүүлэгчээс хүлээн авсан орлогын баримтын дүнг үдийн цай хөтөлбөрт зарлагадсан шаардах хуудасны дүнтэй тулгаж нийт хүүхэд өдрийг 600 төгрөгөөр тооцож үзэхэд зарим сургууль хүүхэд өдөрт ногдох зардлын дүн, эд хариуцагчаас зарцуулсан зардлын бага хэмжээнд илүү, дутуу зөрүүтэй байв. Тухайлбал: Алтанширээ сумын сургууль 2016-2017 оны хичээлийн жилийн үдийн цай хөтөлбөрт хүүхэд өдрөөр зарцуулбал зохих зардал 8179.8 мянган төгрөг байхад эд хариуцагчийн орлого, бэлтгэн нийлүүлэгчид шилжүүлсэн төлбөр 7170.2 мянган төгрөг байгаа бөгөөд 1009.6 мянган төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Хүснэгт №14. Үдийн цай хөтөлбөрийн хүүхэд өдөр

Сар	Хичээлийн жил	үдийн цайнд зарцуулбал зохих			Эд хариуцагчийн		БН-д шилжүүлсэн дүн
		Хүүхэд өдөр	Нэг бүрийг үнэ	Дүн	орлогын дүн	Зарлагын дүн	
1	2016-2017	1,083.00	600.00	649,800.00	649,800.00	649,800.00	649,800.00
2		1,427.00	600.00	856,200.00	856,200.00	856,200.00	856,200.00
3		805.00	600.00	483,000.00	483,000.00	483,000.00	483,000.00
4		1,344.00	600.00	806,400.00	806,400.00	806,400.00	806,400.00
5		1,639.00	600.00	983,400.00	973,800.00	973,800.00	973,800.00
9	2017-2018	1,941.00	600.00	1,164,600.00	1,164,600.00	1,164,600.00	1,164,600.00
10		1,989.00	600.00	1,193,400.00	1,193,400.00	1,193,400.00	1,193,400.00
11		1,562.00	600.00	937,200.00	937,200.00	937,200.00	937,200.00
12		1,843.00	600.00	1,105,800.00	105,800.00	105,800.00	105,800.00
Дүн		13,633.00		8,179,800.00	7,170,200.00	7,170,200.00	7,170,200.00

Төрийн сангаас хүүхэд өдрийг хянаж үдийн цай хөтөлбөрийг санхүүжүүлээгүй байна. Төрөөс иргэдэд олгох тэтгэмж буюу үдийн цай хөтөлбөрийн зардлын төсвийн хэмнэлтийг 2017 онд 62.1 сая төгрөг, 2018 онд 10.2 сая төгрөг, 2019 онд 83.1 сая төгрөг нийт 155.5 сая төгрөгийг бусад сургууль, зардалд зарцуулсан байна.

Үдийн цай хөтөлбөрийн төсвийн хэмнэлтийг зориулалт бусаар зарцуулж, дээд шатны төсөвт 155.5 сая төгрөгийг төвлөрүүлээгүй байна.

- Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт зориулалтын дагуу зарцуулагдсан уу?

Дэлхийн банкны санхүүжилтээр БСШУСЯ-аас хэрэгжүүлж байгаа Боловсролын чанарын шинэчлэл төслөөр сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр 2015-2020 оны хичээлийн жилүүдэд 4 үе шаттайгаар, STEM боловсрол олгох, ангийн номын сан хөтөлбөрүүд тус тус нэг удаа хэрэгжсэн байна.

1. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд сургуулиудын 47 төсөл шалгарч 371.5 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна. Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн төсөл нь бага боловсролын чанарыг сайжруулах, сургалтыг дэмжих, бүтээлч үйл ажиллагааны агуулгыг баяжуулах, хүүхэд бүрийн давуу талыг нээх, илрүүлэх, бага ангийн багш нарын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх зорилготой бөгөөд 5 сургуульд хүүхдийг амьдарч байгаа орон нутгаа таньж мэдэх, хайрлан хамгаалах, бахархах, 3 сургууль ардын өв уламжлал, ёс заншлаа эрхэмлэх, өвлөн үлдэх, 9 сургууль хэл ярианы чадвараа ахиулах, зохиолчдын уран бүтээлтэй танилцаж уншиж бичих чадварыг сайжруулах, номтой нөхөрлүүлэх, 2 сургууль сэтгэн бодох үйл ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн байна.
2. Бага ангийн сурагчдын STEM боловсролд зориулж 2017-2018 онд бүх сургуульд нийт 160.0 сая төгрөгийн хөрөнгө нийлүүлэгдсэнээс 111.6 сая төгрөгийн 450 багц сургалтын хэрэглэгдэхүүн, 48.4 сая төгрөгийн сургалтын ширээ, сандал байна.
3. Бүх сургуулийн 430 ангид 177.7 сая төгрөгийн 16774 ширхэг ном, 50.9 сая төгрөгийн 204 ширхэг номын тавиур нийлүүлэгдсэн байна.

Төсөл хэрэгжсэнээр сургалтын орчин сайжирч, сургалтад ашиглах материаллаг бааз, хэрэглэгдэхүүн нэмэгдсэн, харилцан туршлага судлах, хамтран ажиллах, өөрсдийн үйл ажиллагаагаа бусдад түгээн дэлгэрүүлэх, эцэг эх, олон нийт, сургууль багш нарын хамтын ажиллагаа сайжирсан байна. Харин STEM сургалтын

хэрэглэгдэхүүний ашиглалт зарим сургуульд хангалтгүй байв. STEM сургалтын хэрэглэгдэхүүнийг сургалтын хөтөлбөртөө оруулж хичээлдээ хэрэглэж байхад зарим нь хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар ашигладаг, тус хэрэглэгдэхүүнийг хэрэглээгүй өнөөг хүртэл цоо шинээр нь хадгалж байгаа сургууль байна.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хэрэгжилтэд БСУГ-ын мэргэжилтэн хяналт тавьж ажилласан ба үнэлгээний хороо байгуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй зэрэг зөрчил илрүүлж, төслийн үйл ажиллагааг сурталчлах самбар байршуулах, зарцуулалтын анхан шатны баримтуудыг төслийн тайлангийн хамт бүрэн архивлах, төслийг арвилан хэмнэлттэй зарцуулах, төслийн үйл ажиллагаанаас бодитой үр дүн гаргаж, хүүхэд бүр хийж сурсан зүйлтэй байхыг анхааруулж зөвлөж ажилласан байна.

2017-2019 онд гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн 546.8 сая төгрөгийн ТАХ байна. Үүнд:

- БНСУ-ын соёлын яам, соёлын солилцооны номын сан төлөвлөлтийн газар, БСШУЯ хамтарсан төслөөр Сайншанд сумын 5-р сургуульд 50.0 сая төгрөгийн ном нийлүүлэгдсэн.
- Дэлхийн зөн ОУБ-аас Хатанбулаг суманд 50.0 сая төгрөгийн, Алтанширээ суманд 25.0 сая төгрөгийн ариун цэврийн байгууламжийн хөрөнгө байна.
- Япон улсын ЗГ-ын “Өвсний үндэс” хөтөлбөрөөр Сайншанд сумын 1-р сургууль 2019 онд сургуулийн дотуур байр, насан туршийн боловсролын төвийн байранд 200.0 сая төгрөгийн их засвар хийсэн байна.
- Франц улсын хөрөнгө оруулалттай Бадрах энерги ХХК Улаанбадрах сум сургуулийн дотуур байрны дээврийн засварын 16.4 сая төгрөгийн ажил, Зүүнбаянгийн сургуулийн гадна талбайд 89.9 сая төгрөгийн засвар хийсэн.
- Тайвань улсын гэр бүлийг дэмжих төслөөр Айраг сумын сургууль дотуур байранд 6.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Турк улсын Тика ОУБ-ын санхүүжилтээр Сайншанд I, III сургууль, Замын-Үүд II, III сургууль, Айраг сумын сургуулиудад тус бүр 21.9 сая төгрөгийн эрүүл мэндийн боловсрол олгох иж бүрэн кабинет, эмчийн өрөөг тохижуулсан байна.

Гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр санхүүжигдсэн төсөл хөтөлбөрийг зориулалтын дагуу зарцуулсан ба хөрөнгийг үр дүнтэй ашиглах шаардлагатай байна.

- Сургууль хөгжүүлэх санг үр ашигтайгаар ашиглах нөхцөл бүрдсэн үү?

Сургууль хөгжүүлэх сантай сургууль байхгүй байна.

БҮЛЭГ 2. Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг эзэмшүүлэх зорилго зорилт хангалттай хэрэгжээгүй байна.

Б.1 Ерөнхий боловсролыг олгох хөтөлбөрт нийцсэн чанартай боловсрол олгож байгаа эсэх, сургалтын чанарт үнэлгээ бодитой хийгддэг эсэх

Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн дутагдалтайгаас сургалтын хөтөлбөрийн үр дүн хангалтгүй, сурлагын чанарын, үнэлгээ бодитой бус байна.

Б.1.1 Бүх нийтийн ерөнхий боловсролыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй эзэмшүүлж байгаа эсэх

Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн дутагдалтайгаас хөтөлбөрийн үр нөлөө хангалтгүй байна.

- Эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг бүрэн олгож байна уу? /улсын, хувийн, лаборатори сургуулиудын сургалтын чанар ялгаатай байх/

Аймгийн хэмжээнд 2017-2019 онуудад нийт 22 сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаас бүрэн дунд боловсролын сургууль 10, суурь боловсролын сургууль 10, бага сургууль 1, хувийн өмчийн бага сургууль 1 байна. 2018-2019 оны хичээлийн жилд дунджаар 12664 суралцагч суралцсаны 79.1% хувь нь бүрэн дунд боловсролын сургуульд, 18.5% нь суурь боловсролын сургуульд, 0,9 хувь нь бага сургуульд, 1.5% нь хувийн сургуульд суралцсан байна.

БСШУССайдын 2018 оны А/425 тоот тушаалаар батлагдсан ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмын 3.2-т “Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.” 3.8-д “Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил, хичээлийн жилийн эцэст хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.” гэж заасан байна.

ЕБС-иуд хичээлийн жилийн эхэнд 2-12 дугаар ангийн сурагчдаас гарааны болон оношлох, явцын шалгалт авч сурагч нэг бүрийн түвшинг тодорхойлон тэдгээрт тохирсон хөтөлбөр боловсруулсан байна. Мөн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үр дүнгийн үнэлгээ хийх, зохих мэдлэг чадварыг эзэмшсэн эсэхэд үр дүнгийн шалгалт зохион байгуулах замаар тодорхойлох зэрэг ажлыг зохион байгуулж ажилласан байна.

ЧҮТ-өөс зохион байгуулж байгаа ЧҮС-наас харахад Лаборатори сургуулиудын сургалтын чанар ердийн сургалттай сургуулиас өндөр үнэлэгдсэн байна.

Хүснэгт №15. Сургуулийн хэв шинж болон сурлагын амжилтын хамаарал

№	Сургуулийн нэр	Шалгалтын агуулга / гүйцэтгэлийн хувиар /				Дундаж
		Математик	Монгол хэл	Англи хэл	Физик	
1	Сайншанд лаборатори ЕБС-2	31.0	56.7	25.0	25.4	34.5
2	Сайншанд ЕБС-3	22.1	46.1	17.3	21.4	26.7
3	Замын-Үүд лаборатори ЕБС-1	28.9	55.1	22.6	29.1	33.9
4	Замын-Үүд ЕБС-2	24.6	52.6	16.6	21.5	28.8

Лаборатори сургуулиудын сурлагын амжилт ердийн сургалттай ЕБС-иудаас 5.7-7.8 хувиар илүү байгаа нь дараах хүчин зүйлстэй холбоотой байна. Үүнд:

1. Лаборатори сургуулиуд сургалтын орчноор хангагдсан
2. Багш ажилчдад олгох нэмэгдэл цалингийн хэмжээтэй уялдан мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан
3. Цөм хөтөлбөрийг бусад ЕБС-иудаас түрүүлж хэрэгжүүлсэн, туршлагатай
4. БСШУЯамны харьяанд байдаг зэрэг нь нөлөөлсөн байна.

2018-2019 оны хичээлийн жилийн 9 дүгээр ангийн сурагчдын дунд улсын шалгалтыг 6 хичээлийн агуулгаар зохион байгуулсан байна.

Хүснэгт №16.

Улсын шалгалтын дүн 2018-2019 оны хичээлийн жил-Суурь боловсрол
Суурь боловсрол эзэмшүүлэх сургалттай ЕБС-иуд

№	Сургуулийн нэр	Хичээлийн нэрс, үнэлгээний түвшин											
		Англи хэл		Байгалийн		Математик		Монгол хэл		Нийгмийн		Орос хэл	
		1--4	5--8	1--4	5--8	1--4	5--8	1--4	5--8	1--4	5--8	1--4	5--8
1	Алтанширээ-ЕБС	6	14	4	5	8	12	5	-	6	14	3	8
2	Даланжаргалан-ЕБС	5	8	-	7	-	39	2	37	-	32	6	20
3	Дэлгэрэх-ЕБС	10	14	-	13	7	17	-	24	-	11	-	-
4	Мандах-ЕБС	16	4	-	-	14	6	7	13	7	13	-	-
5	Өргөн-ЕБС	13	9	4	3	18	4	13	9	6	8	-	-
6	Сайхандулаан-ЕБС	2	10	-	-	3	9	2	10	2	10	-	-
7	Уланбадрах-ЕБС	4	10	-	-	9	5	3	11	3	11	-	-
8	Хатанбулаг-ЕБС	10	14	-	-	3	21	11	13	3	21	-	-
9	Хөвсгөл-ЕБС	17	7	1	1	4	20	3	21	12	10	-	-
10	Эрдэнэ-ЕБС	2	24	-	8	23	7	-	30	8	14	-	4
Нийт дүн		85	114	9	37	89	140	46	168	47	144	9	32

Тайлбар: 1-4 дүгээр түвшин хангалтгүй буюу 0-59 оноо,

5-8 дугаар түвшин хангалттай буюу 60-100 оноогоор үнэлэгдсэн байгааг илэрхийлнэ.

Дээрх хүснэгтээс харвал англи хэл, математикийн хичээлийн улсын шалгалтаар 85-89 сурагч, монгол хэл, нийгмийн хичээлийн шалгалтаар 46-47 сурагч тус тус хангалтгүй дүнтэй байна. Сурагчдад эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг бүрэн олгож чадаагүй, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин, лабораторийн тоног төхөөрөмж, сурагчдад олговол зохих боловсролыг үр дүнтэй эзэмшүүлэх сургалтын арга зүй зэрэг хүчин зүйлс сумдын ЕБС-иудад бүрэн бүрдээгүй байна.

Аймгийн ЗДТГ, БСУГ, ЕБС-иуд ЭЕШ-ын бэлтгэлийг чанаржуулах зорилгоор урьдчилсан ЭЕШ зохион байгуулж, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Хүснэгт №17. ЭЕШ-ийн нэгтгэл

№	Сургуулийн нэрс	2017 оны нэгтгэл дүн			2018 оны нэгтгэл дүн			2019 оны нэгтгэл дүн		
		Х.Оноо	Ш.Тоо	Байр	Х.Оноо	Ш.Тоо	Байр	Х.Оноо	Ш.Тоо	Байр
1	Сайншанд-ЕБС-1	510.3	741	4	506.94	806	8	511.8	278	8
2	Сайншанд-ЕБС-2	516.4	465	3	579.6	427	1	541.06	97	3
3	Сайншанд-ЕБС-3	525.8	249	1	517.11	288	5	507.03	48	9
4	Сайншанд-ЕБС-5	517.6	439	2	510.28	330	6	523.72	252	6
5	Айраг сумын ЕБС	496.4	136	5	533.61	135	3	532.73	72	4
6	Замын-Үүд ЕБС-1	479.7	271	7	519.67	329	4	541.67	95	2
7	Замын-Үүд ЕБС-2	476.6	241	8	466.66	301	10	498.71	107	10
8	Замын-Үүд ЕБС-3	472.1	272	10	508.46	220	7	520	72	7
9	Зүүнбаян-ЕБС-4	475.4	86	9	480.24	115	9	530.59	60	5
10	Иххэт сумын ЕБС	462.9	100	11	451.45	107	11			
11	Замын-Үүд -Үлэмж тэнгэр ЕБС	488.2	44	6	566.36	38	2	562.36	10	1
Аймгийн дүн		492.85			512.76			526.97		
Улсад эзэлсэн байр		10			5			3		

ЭЕШ өгөхөд шаардлагатай мэдлэг, чадварыг ахиулах, сурлагын амжилтын үр дүнг хэмжих, Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэх ажлыг зохион байгуулснаар 2017 оноос 34 оноогоор шалгалтын үнэлгээний дундаж оноо ахисан үзүүлэлттэй гарчээ. 2016-2019 оны хичээлийн жилд ЕБС-иуд сургалтын төлөвлөгөөгөөр мэдлэг, чадварыг олгох, сурлагын амжилтын үр дүнг хэмжих, ахиулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн байна.

Салбарын яамнаас батлагдсан сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөрийг ЕБС-иуд хэрэгжүүлэхэд сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, анги танхимын хүрэлцээ бэлэн байгаа эсэхэд дүн шинжилгээ, судалгаа хийгээгүйгээс боловсруулсан тухайн хөтөлбөр нь бүрэн хэрэгжих боломжгүй, хөтөлбөрийн үр нөлөө хангалтгүй байна.

- Нэмэлт сурах бичиг, гарын авлага ашигладаг уу? /салбарын яамны баталсан албан сурах бичгээс бусад нь хүүхдийн суралцах болон биеийн ачаалал, цүнхний жинд нөлөөлдөг эсэх/

Аймгийн БСУГ-ын мэргэжилтний номын захиалга, болон хүлээн авсан баримт, ЕБС-ийн номын санчийн бүртгэл тэмдэглэл зэргээс үзэхэд салбарын яамны баталсан сурах бичгээс өөр нэмэлт сурах бичиг ашиглаагүй байна.

Аймгийн БСУГ-аас бага ангийн сурагчид, ялангуяа 1 дүгээр ангийн сурагчдын цүнхний жингийн талаар сургуулийн удирдлагууд болон 1 дүгээр анги даан ажиллах багш нарт зориулсан сургалтаар зөвлөмж өгч ажилласан байна.

Хичээлийн хуваарийн дагуу бага ангийн хүүхэд өдөрт 3-4 ном цүнхэлж явдаг, 5-6 дугаар анги 7 хоногт 3 удаа 6 цагаар хичээллэдэг, мөн дунд ангийн нэг өдрийн ачаалал 7 цаг байгаа нь хүүхдийн биеийн ачааллыг нэмэгдүүлсэн байна. Яамнаас баталсан сурах бичгээс гадна сургалтын бус нэмэлт хэрэглэгдэхүүн, биеийн тамирын хувцас, үдийн цайны аяга гэх мэт зүйлс хийх, сурагчид хичээлийн хуваарийн дагуу номоо авч явдаггүй зэрэг нь цүнхний жинг нэмэгдүүлж байна. Цүнхний жинд ЕБС-иуд анхаарч дараах ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал:

- Замын-Үүд сумын лаборатори 1 дүгээр сургууль цүнхний жин нь сурагчийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтөд хэрхэн сөргөөр нөлөөлж байгаа талаар мэдээллийн самбар байрлуулж эцэг эхчүүдэд хүүхдийн эрүүл мэндэд анхаарах талаар зөвлөгөө өгч ажилласан байна.
- Замын-Үүд сумын лаборатори 1 дүгээр сургууль, Улаанбадрах, Хөвсгөл сумын ЕБС-иуд жин хэмжих төхөөрөмж суурилуулсан.
- Замын-Үүд сумын 2 дугаар сургууль 1 дүгээр ангид шинээр элсэн орж буй 6 настай хүүхдийн хөгжлийн онцлог, биеийн ерөнхий хөгжлийн тухай сургалтыг эцэг эхчүүдэд зохион байгуулж ажилласан
- Алтанширээ сумын ЕБС-ийн хувьд 2018-2019 оны хичээлийн жилээс 1 дүгээр ангийн хүүхдүүдэд сургалтанд хэрэглэгдэхгүй байгаа сурах бичгийг зөвхөн гэртээ ашиглах зориулалтаар олгож, хөтөлбөрийн дагуу хэрэглэх сурах бичгийг зөвхөн хичээлдээ ашиглах байдлаар зохицуулан, сургууль, гэр хүртэлх замд ном цүнхэлж явахгүй байх зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

Сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, сурагчдын нэг өдрийн хичээллэх хугацаа зэрэг нь хүүхдийн суралцах болон биеийн ачаалал, цүнхний жинд нөлөөлж байна.

Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарт үнэлгээг бодитой хийдэг эсэх

Суралцагчдад мэдлэг, чадварыг хугацаанд нь бүрэн олгож чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, ахиц, амжилтыг тухай бүр үнэлж дүгнэх боломжгүйгээс сургалтын чанарын үнэлгээ бодитой бус байна.

- ЕБ-ын чанарын үнэлгээний судалгааг бодитой, хэвшил хэв шинж харгалзахгүй бүрэн хамруулж хийж байна уу?

БСШУСайдын 2013 оны А/309 тоот тушаалаар батлагдсан ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмын “4.1-т Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангид дараах чиглэлээр авах улсын шалгалтыг сургууль зохион байгуулна.” 5.1-т “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын төгсөх ангийн үндэсний чанарын үнэлгээнд дүн шинжилгээ хийж, боловсролын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан байна. БСШУССайдын 2018 оны А/425 тоот тушаалаар батлагдсан ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмын “6.3-т Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.” гэж заасан байна.

БҮТ-өөс 2017-2018 онд ЧҮС-г төгсөх анги буюу 5, 9, 12 дугаар ангийн сурагчдаас түүврийн аргаар сонгож, улсын шалгалтын хичээлийн агуулгаар судалгаа зохион байгуулж ажилласан байна. 2019 онд ЧҮС-г нийт өмчийн бүх хэлбэрийн ЕБС-ийн суралцагчийн 10 хувиас доошгүй суралцагчийг хамруулах зарчмын дагуу 3, 10 дугаар ангиас анги дэвших шалгалтын агуулгаар түүвэрлэн сонгож, улсын шалгалтын хичээлийн агуулгаар бүх сургуулиудын 9 дүгээр ангийг хамруулан тус тус зохион байгуулжээ.

ЧҮС-г сурагчдаас түүврийн аргаар сонгож зохион байгуулж байгаа боловч тухайн жилд сонгогдсон сургууль дараа жил хамрагдаагүйгээс өмнөх жилийн алдаа, дутагдлыг тус сургууль хэрхэн засаж сайжруулсан, чанарын үнэлгээний

түвшин өссөн, буурсан эсэхэд үнэлгээний судалгаагаар бодитой дүгнэлт гаргах боломжгүй байна.

ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журамд /2017, 2018 онд мөрдөж байсан/ зөвхөн төгсөх ангийн сурагчдаас түүврийн аргаар зохион байгуулахаар тусгасан бол 2018-2019 оны хичээлийн жилээс журам шинэчлэгдсэнээр өмчийн бүх хэлбэрийн ЕБС-ийг хэвшил, хэв шинж харгалзахгүйгээр бүрэн хамруулжээ.

2018 онд 9 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулсан чанарын үнэлгээний судалгаагаар аймгийн дундаж үзүүлэлт 43,9 хувиар хэмжигдэж байсан бол 2019 онд 34,6 хувь болж буурсан нь өмнөх жилүүдэд зохион байгуулагдаж байсан 3 ЕБС-иар хязгаарлагдаагүй аймгийн хэмжээний бүх ЕБС-иудыг хамруулсантай холбоотой байна.

Хүснэгт №18. ЧҮТ-өөс зохион байгуулсан шалгалтын гүйцэтгэлийн мэдээ /БДБ/

№	Шалгалтын агуулга	Улсын дундаж			Аймгийн дундаж		
		2017 он	2018 он	2019 он	2017 он	2018 он	2019 он
1	Математик	27.31	27.5	27.4	22.7	18.23	26.3
2	Монгол хэл	43.78	53.2	49.6	38.6	56.99	61.6
3	Нийгмийн ухаан	37.90	42.5		50.4	41.21	
4	Англи хэл	34.35	46		29.9	45.99	
5	Орос хэл	28.12			30.5		
6	Газар зүй	25.76	42.5	29.8	31.7	54.48	25.0
7	Физик	29.46	23.1		45.5	31.22	
8	Биологи	22.78	32.2	23.6	21.7	23.44	32.8
9	Хими		25.6			28.22	
Ерөнхий дундаж		31.18	36.57	32.58	33.88	37.47	36.4

Суралцагчийн мэдлэг, чадварын үнэлгээний мэдээлэл нууцлалтай, мөн үр дүнгийн үнэлгээ нь зөвхөн анги дэвших, улсын шалгалт байхаар хязгаарлан холбогдох журамд тусгасан байна. Суралцагчдад мэдлэг, чадварыг хугацаанд нь бүрэн олгож чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх болон, ахиц, амжилтыг тухай бүр үнэлж дүгнэх боломжгүй болгосон байна.

- "Сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бодитой үнэлдэг үү?

БСШУССайдын 2018 оны А/425 тоот тушаалаар батлагдсан ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмын 6.1-т "Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ." гэж заасан байна.

БҮТ-өөс 2017-2019 онуудад ЧҮС-нд үндэслэн бага, суурь, бүрэн дунд боловсрол тус бүрийн чанарын үнэлгээний шалгалтын тайланд хичээл бүрээр сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааг гаргасан байна. Судалгаанд суралцагчаас гадна сургуулийн удирдах ажилтан, багш, эцэг эх гэсэн чиглэлээр асуулга боловсруулан авчээ.

Сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэх зорилгоор 2017 онд оршин суугаа газар, хүн ам зүй, сургуулиас, гэр бүлээс, сурагчаас, багшаас хамаарах хүчин зүйлс гэсэн хүрээгээр асуулга авсан ба 2018, 2019 онд өрхийн орчин нөхцөл, өрхийн гишүүдийн харилцаа, найз нөхөд, нийгмийн харилцаа, сургуулийн орчин, багшийн харилцаа хандлага зэрэг асуулга авч суралцагчдын сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйд тус тус шинжилгээ хийж тайланд тусгасан байна.

Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцож байгаа эсэх

Боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналт үр нөлөөгүй, үр дүн хангалтгүй байна.

Б.2.1 Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцож байгаа эсэх

Боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтын арга зүйгээ өөрчилж, хариуцлага, сахилга батыг дээшлүүлэх шаардлагатай байна.

- "Салбарын яамны хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?"

2019 оны 12 сард БСШУС-ын сайдын 2018 оны А/549 дүгээр тушаалаар батлагдсан ЕБС-ийн сайжруулсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Уг үйл ажиллагаанд 22 сургуулийн 25 менежер, 24 багш БСУГ-ын 4 мэргэжилтэн оролцож сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, үр дүнгийн үнэлгээнд үндэслэн сурагчдын сурлагын амжилтыг ахиулахад арга зүйн дэмжлэг үзүүлжээ.

БСШУЯ-аас 2017 онд Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, бага ангийн сурагчдын үдийн цайны үйлчилгээнд тавих хяналтыг 14 чиглэлээр тодорхойлон зааж, хэрэгжилтийг Сургуулийн өмнөх бага боловсролын хэлтсийн цахим хаягаар авах тухай БСУГ-т хандсан, 2018 онд БДБТХ-д заасан захирлын үүргийн талаарх заалтууд, Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмыг хэрэгжүүлэх, боловсролын байгууллагын албан тушаалтны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах, эцэг эх асран хамгаалагч нарт зөвлөгөө өгч хамтран ажиллах, бүх сургуулиудад хэрэгжилийг шуурхай зохион байгуулах чиглэл өгч ажилласан байна.

2018 оны 11 сард эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, цаашид сайжруулах шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлох зорилго бүхий баг бүрэлдэхүүн ажилласан байна. Энэ хүрээнд зөвлөмжийн дагуу БСУГ-аас сургалтын чанарыг сайжруулахаар багш нараас мэргэжлийн шалгалтыг 3 чиглэлээр, сурагчдаас урьдчилсан ЭЕШ авах, 1-9 дүгээр ангийн сурагчдын унших, бичих чадварын суурь судалгааг сургууль багш нартай хамтран хийж ахиц амжилтыг тооцох зэрэг ажлыг зохион байгуулжээ.

БСШУЯ-наас боловсролын байгууллагуудад бодлого, арга зүйгээр хангаж холбогдох дүрэм, журмыг боловсруулан гаргаж, үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж байгаа хэдий ч сургалтын хөтөлбөр агуулга, сургалтын байгууллагын анхан шатны удирдлага, багш нарын ур чадвар, боловсрол, ёс суртахуун, орчин

нөхцөл, эцэг эхийн оролцоо зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүн, хяналт хангалтгүй байна.

- Салбарын яамны зүгээс гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэсэн үү?

2017-2019 онд гадаадын зээл тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн 546.8 сая төгрөгийн ТАХ байгаа бөгөөд салбарын яамны зүгээс төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэсэн баримт материал байхгүй байна.

- Орон нутгийн боловсролын газрын хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

БТХ-ийн 16.2-т “Аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасан.

БСУГ-аас жил бүр ЕБС, цэцэрлэг, соёлын төвүүдэд ажиллах удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлсэн байна. Сургуулиудад багш нарын ажил, сургуулийн хүүхэд хамгааллын ажил үйлчилгээ, дотуур байрны үйл ажиллагаа зэрэгт тоон ба чанарын шалгуур үзүүлэлтээр оноо өгч үнэлсэн ба мэргэжилтнүүд өөр өөрийн хариуцах чиглэлээр хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг бичиж дүгнэн, цаашид анхаарах зүйлс болон зөвлөмж өгсөн байна.

2018 оны 4 сард хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ сургуулийн сурагчид, багш, ажилтан, эцэг эхчүүд, дотуур байрны сурагчдаас боловсролын үйлчилгээний чанар, багш ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлага, сургалтын чанарын асуудлаар сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг сургуулийн хамт олонд танилцуулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга зам, анхаарах асуудлаар зөвлөмж өгч ажилласан байна. Хэрэгжүүлсэн хяналт шалгалт, зөвлөн туслах үйл ажиллагааны дүнд үндэслэн сургуулиудад дараах зөвлөмж өгсөн байна.

Санал асуулгын дүнгээр:

1. Үдийн цайны асуулгын нэгтгэл: Мандах, Айраг, Өргөн, Эрдэнэ Сайншанд 1, 2, 3, 5, -р сургууль, Замын-үүд сумын 1, 2, 3-р Сургуулийн үдийн цай хөтөлбөрт сурагчдын сэтгэл ханамж хангалтгүй. Хоолноос чулуу, хорхой, хумс, гардаг, давс, өөх ихтэй, хоолны амт муу гэсэн санал ирсэн байна.

2. Багш нараас авсан санал асуулгын нэгтгэл: Хөдөө орон нутагт ирж ажиллаж байгаа багш нарыг байраар хангах, залуу багш нарыг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх, бичиг цаасаар голлох биш сурагчдын сурлагын чанараар шалгадаг байх, сурах бичгийн агуулгыг цэгцэлж багасгах, захирал, эрхлэгчийг БСУГ-аас томилох, удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, захирал, менежерүүдийн чадвар сул байгаад анхаарах, ЭЕШ-ийн дүн оноогоор багшийн ажлыг үнэлэхгүй байх, багш нарын хөгжилд анхаарах, эцэг эхчүүдийн хандлага, төлөвшлийг өөрчлөх, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулах, бага ангиас дунд ангид уншиж чадахгүй хүүхэд орж ирдэг, сургалтын менежерүүдийн удирдах арга барил хоцрогдсон, багш өөрөө арга зүйгээ өөрчилж, сэтгэлтэй ажиллах,

3.Эцэг эхийн санал асуулгын нэгтгэл: Хүүхдийн төлөө үнэн сэтгэлээсээ хандах хандлага, тулж ажиллах арга барил дутмаг, үзвэр үйлчилгээг хүүхдүүдэд шахах асуудлыг болих, хүүхдүүдийг олон үйл ажиллагаанд хамруулах, урлаг, спортын арга хэмжээг зохион явуулах, эцэг эхийн зөвлөлөөр далимдуулж анги цэвэрлэгээ, фондны мөнгө гэх мэт мөнгө хураадаг, бусдыг хүндлэх, ёс суртахуунд нөлөөлөхүйц арга зүйг нэвтрүүлэх,

4. Дотуур байрны хүүхдийн санал асуулгын нэгтгэл: Хоолны мөнгийг нэмэх, порц бага, хоолондоо цаддаггүй, багш, ажилчдыг хүндлэх, найзуудаа хүндлэх, соёлтой байхад суралцах, дотроо ариун цэврийн өрөөтэй, усанд ордог баймаар байна, жижүүрүүдийн харилцаанд анхаарах, өвөл халаалтаа сайжруулах гэсэн санал гаргажээ.

БСУГ-аас сургуулиудын хөрөнгийн ашиглалт, чанар байдалд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлүүлэх ажил хангалтгүй байна. Тухайлбал: Сайншанд сумын 1-р сургуулийн химийн кабинетад ОХУ-ын тусламжаар баригдсан сургуулийн барилгын хамт дагаж ирсэн олон төрлийн химийн бодисууд, 2003 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ирсэн урвалж бодисууд байдаг байна. Нийт 148 нэр төрлийн хугацаа дууссан бодис зориулалтын бус байранд хадгалагдаж байна.

Замын-Үүд сумын 1-р сургуулийн барилгын ашиглагдах хугацаа дууссан, Замын-Үүд сумын 3-р сургуулийн барилгын хана цуурч, салхи шороо ордог тул спорт заал, урлаг зааланд өвлийн улиралд хичээл орох боломжгүй болсон байна.

БСУГ-аас жил бүр хяналт тавьж, зөвлөн туслах үйл ажиллагааг явуулж ирсэн ч сургуулиуд зөвлөмжийг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлээгүйгээс хяналт шалгалтын үр дүн хангалтгүй байна.

- Байгууллагын түвшинд дотоод хяналт хэрэгжиж байна уу? /ерөнхий боловсролын сургуулиуд/

БСШУС-ын 2010 оны 471 дүгээр тушаалаар баталсан ЕБС-ийн үлгэрчилсэн дүрмийн 2.9-д “Сургуулийн үйл ажиллагаа, сургалтын үйл явц, чанар, үр дүнд өөрийн үнэлгээ өгөх чиг үүрэг бүхий багш, суралцагч, эцэг, эхийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн хяналт-шинжилгээний баг ажиллуулна”, 2.16.1-д “Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журамд нийцүүлэн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг сургалтын явцад, анги дэвших, сургууль төгсөхөд нь үнэлж дүгнэх болон сурлагын амжилтын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх график, төлөвлөгөөтэй байна” гэж заасан.

Сургуулиудад дотоод хяналтын орон тооны ажилтангүйгээс нийгмийн ажилтан, багш 3-5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт хийх ажлын хэсгийг томилж ажиллуулсан байна. Ихэнх сургуулиуд дотоод хяналтын журмаа ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын хүрээнд шинэчлэн боловсруулсан, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө гаргасан байна. Дотоод журам, гаргасан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлээгүй, төлөвлөгөөндөө хяналт хэрэгжүүлэх хууль эрхзүйн заалтууд болон хөндлөнгийн байгууллагуудын хяналтаар илрүүлсэн зөрчлийг арилгах талаар төлөвлөгөөндөө тусгаагүй байна. Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлээгүй, хяналтаар илрүүлсэн зөрчлийг

удирдлагад танилцуулах, өгсөн зөвлөмжийн биелэлтийг эргэж хянаагүй байдал түгээмэл байна.

БСШУС-ын 2010 оны 471 дүгээр тушаалаар баталсан ЕБС-ийн үлгэрчилсэн дүрэмд тусгасан үйл ажиллагааны мэдээллийг цахим хуудаст байршуулан эргэх холбоог хангаж ажиллана, сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх гэсэн заалт болон Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журмаар хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөгөөндөө тусгаагүй, энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулаагүй байна. Тухайлбал сургуулийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн жилийн бүтэц, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, боловсролын баримт бичиг, шалгалтын хуваарь, хичээлээс гадуурх сургалтын ажил, санхүүжилт, төлбөр, хураамж, санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсан талаар цахим хуудсаар мэдээлэл байршуулаагүй байна.

Боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших явцыг удирдах, зохион байгуулах, эцэг эх асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа дэмжлэг үзүүлэх гэсэн үндсэн зорилт бүрэн хангагдаагүй байна.

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тооцож байна уу? /яамны болон хөндлөнгийн/

Боловсролын тухай хуулийн 37.1-д “Боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу БСШУЯ-ны харьяа Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төвөөс БСШУС-ын 2013 оны А/309 тоот тушаалаар баталсан “ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ын дагуу сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийсэн байна.

Чанарын үнэлгээний төвөөс зохион байгуулсан судалгаанд 2017 онд Сайншанд сумын 1-р сургууль, 5-р сургууль, Айраг сумын сургуулийн Y, IX, XII ангийн нийт 362 сурагч, 2018 онд Сайншанд сумын лаборатори 2-р сургууль, 3-р сургууль, Замын-Үүд сумын лаборатори 1-р сургуулийн Y, IX, XII ангийн нийт 273 сурагч, 2019 онд Сайншанд сумын лаборатори 2-р сургууль, 1-р сургууль, Замын-Үүд сумын лаборатори 1-р сургуулийн бага, дунд боловсролын III, X ангийн, бүх сумын сургуулийн IX ангийн сурагчид нийт 1163 сурагч хамрагдсан байна. Бага, суурь, бүрэн дунд боловсролын аймгийн дундаж хувь улсын дунджаас доогуур байна.

Чанарын үнэлгээний дүнг БСУГ-аас сургуулиудад мэдээлдэг хэдий ч сургуулиуд сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө хөтөлбөр боловсруулж ажиллаагүй байна.

БСШУС-ын 2003 оны 321 дүгээр тушаалаар баталсан ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үнэлгээ өгөх үзүүлэлтүүдийн дагуу БСУГ-аас 2017 онд 16 сургуулийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх удирдамж баталж, /Дэлгэрэх, Алтанширээ, Иххэт суманд шүлхий өвчний улмаас ажиллаагүй/ сургуулийн дараах үйл ажиллагааг хамруулж шалгасан байна.

Боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилт /мэргэжил тус бүрээр/, бүтэц орон тоо, үр дүн, ур чадварын үнэлгээ, ирцийн бүртгэл, төлбөр, түрээс, АУБ-ын хичээл бүрийн ахиц, амжилт, мэргэжлийн зэрэг, хүчинтэй хугацааг хянах, ЭЕШ-ийн урьдчилсан шалгалтын мөрөөр хийгдэж байгаа ажил, цахим хичээлийн сан, сурах бичиг ашиглалт, сургалтын менежер болон нийгмийн ажилтны үйл ажиллагаа, дотуур байр, насан туршийн боловсролын үйл ажиллагаа, багш, суралцагч, эцэг эхээс санал асуулга авах зэрэг өргөн хүрээнд хэрэгжүүлсэн байна.

Сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг идэвхжүүлж байна.

- Сургалтын хөтөлбөрт тавих шат шатны хяналт хэрэгжиж байна уу? /төрийн болон хувийн өмчийн/

Сургуулиуд сургалтын хөтөлбөрөө БСШУС-ын 2014 оны А/240, 2015 оны А/220, 2017 оны А/61, 2018 оны А/453, болон БСШУС-ын сайдын 2019 оны А/491 дүгээр тушаалаар батлагдсан “ЕБС-ийн бага, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөө”-г үндэслэн боловсруулж байна. БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 тушаалын хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 15-д заасны дагуу сургуулийн сургалтын менежер нь стандартыг хэрэгжүүлэх болон багшийн бусад ажлын гүйцэтгэлийг сар, улирлаар тооцож, сургуулийн захирлаар батлуулсан, багш нарын боловсруулсан хичээлийн судлагдахуун тус бүрийн хөтөлбөрийг тухайн сургуулийн сургалтын менежер нь хянаж баталсан байна.

Б.2.2 ЕБ олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг тооцож байгаа эсэх

Сургуулиудын үйл ажиллагаанд тавьсан хяналтаар илэрсэн зөрчил давтагдан гарч байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна.

- Мэргэжлийн байгууллагуулын зүгээс үр нөлөөтэй хяналт шалгалт хэрэгжүүлж байна уу?

Мэргэжлийн хяналтын газраас ерөнхий боловсролын сургуулиудад МХЕГ-ын болон МХГ-ын даргын удирдамжаар 2016-2019 онд давхардсан тоогоор 15 сургуульд хяналт шалгалт хийсэн байна. Шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлөөс дурдвал:

1. Хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын орчны хүрэлцээ хангамж: Мэдээлэл зүй, хими, физикийн хичээлийг дадлагын кабинетэд хичээллэдэггүй, хичээлд хэрэглэх тоног төхөөрөмж хүрэлцээгүй, байгаа хэрэглэгдэхүүн, урвалж бодис нь шаардлага хангаагүй, бага боловсролын агуулгын хүрээнд нийцсэн заавал унших ном хүрэлцээгүй, мэдээлэл, технологийн кабинетэд галын хор байрлуулаагүй, сургуулийн гадна талд биеийн тамирын талбай байхгүй, номын сангийн уншлагын талбайн хэмжээ бага, ширээ сандал хүрэлцээгүй,

2. Мэргэжлийн багш нарын хүрэлцээ, мэргэжил арга зүй, ур чадвар : Багшлах эрхгүй багштай, мэргэжлийн бус багш, нийгмийн ажилтан, номын санчийг ажиллуулсан, мэргэжлийн багш дутагдалтай, биеийн тамирын гадаад талбайг

сургалтад ашигладаггүй, хүүхдийг бие дааж хөгжүүлэх үйл ажиллагаа зохион явуулдаггүй,

3. Хичээлийн хөтөлбөр, дүн шинжилгээ: боловсролын үнэлгээний төвийн болон мэргэжлийн байгууллагын хөндлөнгийн үнэлгээ хоорондын зөрүү 30 хувиас бага, сургалтын агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг чадварыг бататгах, сургалтыг дэмжихэд мэтгэлцээн, ярилцлага, хэлэлцүүлэг, бусад олон нийтийн ажлыг зохион байгуулаагүй,

4. Дотоод хяналт: Зарим сургууль холбогдох хууль тогтоомжийн дагуу дүрмээ боловсруулаагүй, дотоод хяналтын тогтолцоо төлөвшөөгүй, шалгалтын тайлан, үр дүнг хамт олонд танилцуулдаггүй, бага боловсролын стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр улиралд нэг удаа, хичээл тус бүрт дүн шинжилгээ хийгээгүй, сургуулийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, сургалтын чанарын үнэлгээ хийх боломж бүрдээгүй, сургуулийн бодлого төлөвлөлт, бусад ажил үйлчилгээнд сурагч, эцэг эхчүүдээс санал авдаггүй зэрэг зөрчил илрүүлж зөвлөмж өгсөн байна.

Тухайн сургууль болон бусад сургуулиудад гарсан зөрчлийн шинж чанар нь ижил төстэй, давтагдан гарсан байна.

МХГ-аас өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа тууштай, хариуцлагатай хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсаар байна.

- Эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт, үүрэг оролцоо хангалттай, үр дүнтэй байна уу?

Эцэг эх, сургуулийн хамтын ажиллагааг сайжруулах, боловсролын талаарх олон нийтийн ойлголтыг эерэг болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Эцэг эх, хүүхдээ сонсьё-444" арга хэмжээг сар бүрийн 4 дэх долоо хоногийн 4 дэх өдрийн 16 цагт аймгийн бүх сургуулиуд хэрэгжүүлж хэвшсэн байна.

Сургуулиудын Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд Засаг даргын тамгын газар, МХГ, эцэг эх, олон нийтийн төлөөллөөс тавих хяналтыг хэрэгжүүлж зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч ажилласан байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд сургуулийн захирал, цагдаагийн байгууллагын төлөөлөл уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ байгуулсан ба SCHOOL POLICE эргүүлийг 8 сургуулийн сурагчдын эцэг эх хоёр ээлжээр сургуулийн орчинд 16 цагаар үүрэг гүйцэтгэн хяналт тавьж ажилласнаар сургуулийн орчинд гэмт хэрэг үйлдэгдээгүй байна.

Боловсролын тухай хуулийн 29.1.1-т "боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх" гэж заасан.

Аймгийн ИТХ-аас "Эрүүл аюулгүй, ээлтэй орчинд суралцах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэн стандартад суурилсан үйлчилгээг хэрэглэгч бүрд хүргэх, хүүхдийг эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, амьдрах ухаантай, эх оронч иргэн болгон төлөвшүүлэх" зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын чиглэлүүдээр хяналт тавьж ажилласан байна. Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэн батлахдаа өмнөх жилийн биелэлтийн талаарх тайлан, тухайн жилийн хэрэгжилтийн явцыг хурлаараа хэлэлцдэг ба ерөнхий боловсролын асуудлаар тусгайлсан төлөвлөгөө баталж, түүндээ хяналт тавьж ажилласан үйл ажиллагаа байхгүй байна.

Аймгийн ИТХ-аас "Маргаашийн нар багшийн гар дээр мандана", "Хөрш орноосоо суралцъя", "Эх хэл бичиг-Бидний өв соёл" дэд хөтөлбөрүүдийг баталж,

хэрэгжилтэд хяналт тавьж 2 жил тутам хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн байна. Аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Хороод, ажлын албанд боловсролын байгууллагатай холбогдох өргөдөл, гомдол ирээгүй, ИТХ-аас хяналт шалгалт хийгээгүй байна. ЭМГ-ын гаргасан тоон судалгаагаар 18 нас хүртэлх охидын жирэмслэлт, бэлгийн замаар халдах өвчин, бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол цөөн тоогоор бүртгэгдсэн тул аймгийн ИТХ-аас 2018 онд Аймгийн ЭМГ-тай хамтран эрүүл мэндийн хөтөлбөрийг өсвөр үеийнхэнд таниулах, эрүүл мэндээ хамгаалах, амьдралын зөв дадал хэвшилтэй болоход нь туслах зорилгоор Сайншанд сумын ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад хадварт өвчин, нөхөн үржихүйн талаар яриа таниулга хийсэн байна.

Засгийн газраас "Төрийн албан хаагчдын сахилга дэг журмыг чангатгах тухай" тогтоол гарсантай холбоотой аймгийн Засаг даргаас боловсролын байгууллагын албан хаагчдын сахилга дэг журмыг чангатган хариуцлага алдсан албан хаагчдад арга хэмжээ авах, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, ажлын байранд архи согтууруулах ундаа, сансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис нэвтрүүлэхгүй байх талаар чиглэл хүргүүлж, тайланг улирал бүр авч ажилласан байна.

Эцэг эх, олон нийтийн зүгээс боловсролын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч үр дүн хангалтгүй байна.

Холбогдох байгууллагын санал:




ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: (705) 2-39-77, факс: (705) 2-36-77,
Вэб сайт: dornogovi@mecs.gov.mn

2020.10.30 № 311
танай 2020.10.29-ны № 1-6/461 -т

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг хүлээн авч танилцлаа. Дүгнэлт, зөвлөмжтэй холбогдох санал үгүй болно.

ДАРГА  Ч.ОТГОНБАЯР



У.Мунгунмаа
Тайланг дуусгах.
2020.10.30


442200902

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Зарим эрх зүйн актыг бодит байдалд нийцүүлж өөрчлөөгүйгээс гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр нөлөө хангалтгүй, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.
- Шинэ барилгыг ашиглалтад хүлээн авахдаа барилгын чанар, ажлын гүйцэтгэлийг хангуулаагүйгээс ашиглагч байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэсэн, барилга байгууламжийн эрүүл ахуй, аюулгүй байдал алдагдсан нь хичээл сургалтын хэвийн үйл ажиллагаа тасалдах, багш ажилтан, хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж байна.
- Сургуулиудад мэргэжлийн бус хүн ажилласан нь суралцагч эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмших боломжгүй болох үр дагавартай байна.
- Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу 15 жил тутам сургуулийн барилга, дотуур байрны барилгад төлөв байдлын дүгнэлт гаргуулаагүй байна.
- Химийн хичээлийн хугацаа дууссан урвалж бодисыг хадгалах, устгах асуудал шийдвэрлэгдээгүй байна.
- БСШУЯ-наас сургуулиудад нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж, ширээ сандал, шүүгээ, эд зүйлсийн үнэ өндөр, чанаргүй, ирсэн зарим хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үнэ цэнэ, үр өгөөжийг бууруулж байна.
- Үйл ажиллагаа эхлээгүй сургуулийн урсгал зардалд батлагдаж ирсэн 1976.9 сая төгрөгийн төсөв, санхүүжилтийг боловсролын салбарын хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хоолны зардал, үдийн цай хөтөлбөрийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 742.0 сая төгрөгийг бусад сургууль болон зардалд хуваарилан зарцуулсан байна.
- Сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, анги танхимын хүрэлцээ бэлэн байгаа эсэхэд дүн шинжилгээ, судалгаа хийгээгүйгээс боловсруулсан тухайн хөтөлбөр нь бүрэн хэрэгжих боломжгүй, хөтөлбөрийн үр нөлөө хангалтгүй байна.
- БСШУЯ, БСУГ, МХГ-аас жил бүр хяналт тавьж, зөвлөн туслах үйл ажиллагааг явуулж ирсэн ч сургуулиуд зөвлөмжийг үйл ажиллагаандаа тууштай хэрэгжүүлээгүйгээс хяналт шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

Аудитаар нийт 2718.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, хүүхдийн сургалтын орчны аюулгүй байдлыг хангуулах асуудлыг шийдвэрлүүлэх, шаардлага хангахгүй, хугацаа дууссан химийн бодисыг мэргэжлийн байгууллагаар устгуулах 4 албан шаардлага бичиж, холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж хүргүүлээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Аймгийн Засаг дарга танаа:

1. Төсвийн тухай хуулиар олгогдсон төсөв зарцуулах, хуваарилах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргээ хэрэгжүүлж хяналт тавьж ажиллах


Боловсрол, соёл урлагийн газрын дарга танаа:

1. Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаатай холбоотой нөхцөл байдал, үй ажиллагаанд зөрчигдөж буй, хоорондоо нийцээгүй дүрэм, журам зааврыг холбогдох байгууллагад уламжилж санал оруулах
2. Сургуульд төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн техник хэрэгслийн ашиглалтад хяналт тавьж, хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах
3. Багш, ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагатай хамтарч ажиллах
4. Төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх

Ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад:

1. Ерөнхий боловсролын сургуулийн барилга, дотуур байрны барилгын төлөв байдлын дүгнэлт гаргуулж ажиллах
2. Ерөнхий боловсролын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрхзүйн актын хүрээнд ажиллаж, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах тухай зөвлөмжийг тууштай хэрэгжүүлэх
3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулж дотоодын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

ХАВСРАЛТУУД:

Хавсралт


Хавсралтын дугаар	Судалгааны маягтын нэр
<i>Нэг</i>	<i>ЕБС-ийн сургалтын орчны судалгаа</i>
<i>Хоёр</i>	<i>ЕБС-ийн орон нутгийн хэрэгцээ шаардлага, хамран сургалтын судалгаа</i>
<i>Гурав</i>	<i>Багш боловсон хүчний судалгаа</i>
<i>Дөрөв</i>	<i>Төрийн өмчийн сургуулиудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн судалгаа</i>

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Ахлах аудитор

Гэрээт ажилтан

Гэрээт ажилтан




Ц.Лүндэгмаа

З.Давааням

Б.Ариунбаатар

ХЯНАСАН:

Аудитын менежер



Ч.Хэрлэнчимэг

Аудитын явцад хамтран ажилласанд талархал илэрхийлье.



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/43

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, 2018 оны А/207 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, 01/106 ДГА-2020/05/-ГА, 02/107 ДГА-2020/05/-ГА, 03/108 ДГА-2020/05/-ГА, 04/109 ДГА-2020/05/-ГА дугаар бүхий албан шаардлагыг тус тус баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга, аймгийн БСУГ-ын газрын дарга, ЕБС-ийн захирал нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг УАГ, аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, БСУГ-ын дарга нарт хүргүүлсүгэй.
4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ч.АРИУНАА



440010077